



МОНГОЛ УЛСАД ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



ЦАГДААГИЙН
ЕРӨНХИЙ
ГАЗАР



ДОТООД
ХЭРГИЙН ИХ
СУРГУУЛЬ



ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ЯВДЛЫН
ШАЛТГААН, НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Судалгааны тайлан

Улаанбаатар хот
2021 он

Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам

© Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан, Улаанбаатар, 2021

НҮБ байр, Нэгдсэн Үндэстний Гудамж-14
Улаанбаатар 14201, Монгол

2021 оны 6-р сар

Энэхүү тайлан нь НҮБ-ын Хүүхдийн сангийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно. Уг тайлангийн хэвлэн нийтлэх эрх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Санд байна. Тус тайланг хэсэгчлэн болон бүхлээр нь дахин хэвлэх/өөрчлөх/зураг хэлбэрээр хуулбарлахдаа НҮБ-ын Хүүхдийн санд бичгээр зөвшөөрөл хүсч авна уу.

Та бүхэн дор бичсэн хаягаар холбогдож дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

НҮБ байр, Нэгдсэн Үндэстний Гудамж-14
Улаанбаатар 14201, Монгол

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА:

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Цагдаагийн сургууль

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА:

Шүүхийн ерөнхий зөвлөл

Улсын ерөнхий прокурорын газар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн

АГУУЛГА

Товчилсон үгс
Нэр томъёоны тайлбар
Графикийн жагсаалт
Хүснэгтийн жагсаалт
Зургийн жагсаалт

УДИРТГАЛ 8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН 10

- 1.1. Эрүүгийн хууль
- 1.2. Зөрчлийн тухай хууль
- 1.3. Хүүхдийн эрхийн тухай хууль
- 1.4. Садар самуунтай тэмцэх тухай хууль
- 1.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 1.6. Хүүхэд хамгааллын тухай хууль

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ, ЦАХИМ ОРЧИН 14

- 2.1. Монгол Улс дахь цахим хэрэглээний төлөв байдал
- 2.2. Цахим орчноос хүүхдэд учрах эрсдэл

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, НӨХЦӨЛ 22

- 3.1. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг
- 3.2. Цахим гэмт хэргийн хохирогч
- 3.3. Цахим орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч
- 3.4. Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАХИМ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА 32

- 4.1. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал
- 4.2. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гадаадын зарим улсын туршлага

ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ 46

АШИГЛАСАН МАТЕРИАЛ 53

ТОВЧИЛСОН ҮГС

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
МДШШУА	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба
МУГХУСАЗЗ	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХХЭ	Олон улсын харилцаа холбооны эвлэл
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХСИС	Хууль сахиулах их сургууль
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн

ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- **Цахим** гэж Монгол хэлний тайлбар тольд зааснаар цахилгаан тооцоолон бодох техник, ийм төрлийн техник ашиглан үйл ажиллагаа явуулах, цахим бараа, цахим тооцоолуур, цахим захиа, цахим шуудан, цахим багаж, цахим тоноглол, цахим карт, цахим хуудас хэмээн томьёолсноос гадна маш хурдан, цахилгаан цахих мэт хурдтай, цахим хурдыг ойлгоно¹.
- **Цахим хэрэглээ** гэдгийг гар утас, компьютер, таблет зэргийг дангаар болон интернет, сүлжээний орчинд хэрэглэхийг ойлговол зохино².
- **Цахим орчин** гэж хүн төрөлхтний мэдлэг, мэдээлэл харилцан солилцох хэрэгцээнээс үүдэлтэй интернет, сүлжээгээр холбогдсон гар утас, таблет, компьютеруудын сүлжээг ойлговол зохино³.
- **Цахим орчин дахь гэмт явдал** гэж гар утас, компьютер, таблет зэргийг дангаар болон интернет, сүлжээний орчинд хэрэглэх явцад бий болсон гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийг хамруулан ойлговол зохино⁴.
- **Хүүхдийн эсрэг хүчирхийлэл** гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие мах бодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгоно⁵.
- **Нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт** (Crime prevention through social development) гэж тухайн улс, орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа нийгмийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө эсхүл зорилтот бүлгүүдэд чиглэсэн ажил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тусламж дэмжлэгт тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг хэлэх бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулдаг⁶.
- **Олон нийт, орон нутагт суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт** (Community or locally-based crime prevention) гэж орон нутаг тэр дундаа жижиг хот сууринд (аймаг, сум) төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой бөгөөд микро түвшний нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ. Орон нутгийн иргэдийн харилцаа, олон нийтийн оролцоонд тулгуурлаж, тэдгээрийг урамшуулах, хамтран ажиллах хэлбэрийг дэмжиж, нутгийн иргэдийн харилцаа, итгэлцэл, хамтын үнэт зүйлсэд суурилан хийгддэг⁷.
- **Шалтгаан нөхцөлд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт** (Situational crime prevention) гэж гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг шинжилгээ, судалгааны тусламжтай тогтоож, түүний шалтгаан

¹ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. <https://toli.query.mn>. хандалт 2021.02.19

² Судалгааны багаас холбогдох судалгааны тайлан, хууль тогтоомж, онолын эх сурвалжид тулгуурлан томьёолсон болно.

³ Судалгааны багаас холбогдох судалгааны тайлан, хууль тогтоомж, онолын эх сурвалжид тулгуурлан томьёолсон болно.

⁴ Судалгааны багаас холбогдох судалгааны тайлан, хууль тогтоомж, онолын эх сурвалжид тулгуурлан томьёолсон болно.

⁵ Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016. <https://www.legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>. Хандалт 2021.02.19

⁶ Г.Оюунболд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй. УБ. 2017

⁷ Г.Оюунболд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй. УБ. 2017

нөхцөлийг арилгах, гэмт хэрэг гарах эрсдэлийг бууруулахын тулд авч хэрэгжүүлж байгаа менежмент, дизайн, техникийг төлөвлөн, оновчтой шийдвэр гаргах гаргах цогц үйл ажиллагаа⁸.

- **Нийгэмшүүлэх хөтөлбөр** гэж тухайн улс төрийн бодлогоор зорилтот бүлэгт чиглэсэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Тухайлбал, хууль буюу захиргааны хэм хэмжээний актад заасан хүүхэд, донтох өвчтэй хүн, хүчирхийлэл үйлдэгч, эсхүл гэмт хэргийн хохирогчийг эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлдэг⁹.
- **Хүүхэд хамгаалал** гэж нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагааг хэлнэ.¹⁰
- **Хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл** гэдэгт:(a) хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд бэлгийн харьцаанд орох насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн харьцаанд татан оролцуулах¹¹, (b) хүүхдийг бэлгийн харьцаанд татан оролцуулахдаа: албадсан, заналхийлсэн, эсвэл итгэл хүлээлгэсэн байдлыг ашиглан дарамталсан, гэр бүл доторх эрх мэдэл, нөлөөллийн хүчээ хүүхдэд давуулан ашигласан, эсвэл хүүхдийн сэтгэцийн эмгэг, хөгжлийн бэрхшээл, хараат байдал зэрэг эмзэг өртөмтгий байдлыг ашиглан дарамтлах зэрэг орно¹².
- **Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг** гэж хүүхдийг садар самуун явдалд ашиглах, хүүхэд оролцсон садар самуун явдалд мэдсээр байж оролцох, хүүхдийн биеэ үнэлэлтэд хүүхдийг оролцуулах, бэлгийн харьцаанд хүүхдийг оролцуулахдаа биеийг нь үнэлүүлэх замаар ашиглах зэрэг үйлдлийг хэлнэ¹³.

⁸ https://www.unodc.org/pdf/criminal_justice/Handbook_on_Crime_Prevention_Guidelines_-_Making_them_work.pdf

⁹ https://www.unodc.org/pdf/criminal_justice/Handbook_on_Crime_Prevention_Guidelines_-_Making_them_work.pdf

¹⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 19 дүгээр зүйл нь улс орнуудаас хүүхдүүдийг хүчирхийллийн бүхий л хэлбэрээс хамгаалах талаар хууль тогтоомж, засаг захиргаа, нийгэм, боловсролын зохих арга хэмжээг авахыг шаарддаг.

¹¹ It should be noted that Article 18(3) sets forth that Article 18(1)(a) does not cover consensual sexual activity between children

¹² 2007 онд батлагдсан Ланзаротегийн конвенц, 18(1) зүйл

¹³ 2011 онд батлагдсан ЕХ-ны удирдамж 2011/93-д бэлгийн мөлжлөгт хамаарах зөрчлүүдийг 4-р зүйл

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1	Цахим хэрэглээний зорилго
График 2	Цахим орчин дахь сөрөг мэдээлэл
График 3	Цахим орчинд ямар мэдээлэл оруулах нь аюулгүй болох талаарх ойлголт
График 4	Эцэг эхийн төсөөлөл, мэдлэг
График 5	Сэтгэл санаа тогтворгүй болсон шалтгаан
График 6	Хүүхэд хохирсон гэмт хэрэг
График 7	Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэг
График 8	Гэмт хэрэг тоо, 2015-2019 он
График 9	Өртөж байсан цахим гэмт халдлагын төрөл
График 10	Цахим гэмт халдлагад өртөөд цагдаад хандаагүй шалтгаан
График 11	Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч /2015-2019/
График 12	Хохирогчдын хүйс
График 13	Хохирогчдын насны ангилал, хүйс /2015-2019/
График 14	Цахим гэмт хэрэг үйлдэгчид оноор
График 15	Гэмт хэрэг үйлдэгчдийн насны байдал
График 16	Гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдал
График 17	Гэмт хэрэгтнүүдэд үйлдсэн гэмт хэргийн төрөл, оноосон ял шийтгэл
График 18	Гэмт хэрэг үйлдэгчид ба тэдний ажил мэргэжлийн хамаарал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Эрсдэл
Хүснэгт 2	Садар самуун агуулга бүхий мэдээлэл хүлээн авсан эсэх
Хүснэгт 3	Бүртгэгдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн зүйл, ангиар
Хүснэгт 4	Шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл огноогоор
Хүснэгт 5	Өртөж болзошгүй халдлага насны бүлгээр

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Гар утас ашиглалтын мэдээлэл
Зураг 2	Монгол Улсын интернет хэрэглэгч
Зураг 3	Монгол Улсын интернетийн үйлчилгээ үзүүлэгч
Зураг 4	Unfriend хөдөлгөөнд ашиглагдсан зурагт сурталчилгаа
Зураг 5	Unfriend хөдөлгөөнд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа
Зураг 6	Цахим орчинг зөв бол Гоё аянд ашиглагдсан зурагт сурталчилгаа
Зураг 7	Цахим орчинг зөв бол Гоё аянд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа
Зураг 8	Зөвийг түгээе аянд ашиглагдсан зурагт сурталчилгаа
Зураг 9	Зөвийг түгээе аянд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа
Зураг 10	Канадын хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоо
Зураг 11	Германы хүүхэд хамгааллын тогтолцоо
Зураг 12	БНСУ-ын хүүхэд хамгааллын тогтолцоо
Зураг 13	IWF Цахим хуудас
Зураг 14	IWF Цахим хуудас

УДИРТГАЛ

Монгол Улсад цаг тутамд өсөн нэмэгдэж буй компьютер, таблет, ухаалаг утасны хэрэглээнээс шалтгаалан цахим гэмт хэрэг өсч, үүний улмаас хүүхэд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх явдал ихсэх хандлагатай байна. Иймд энэ төрлийн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж, гэмт хэргийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын энэ төрлийн гэмт хэрэгт тавих хяналтыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, цахим сүлжээг зөв зохистой хэрэглэх, аюулгүй байдлаа хангах шаардлага тулгарч байна.

Манай улсад хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон, ялангуяа цахим орчинд хүүхэд хохирсонтой холбоотой асуудлыг хөндсөн хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн байна. Тухайлбал, 2018 онд ХЗҮХ-ээс “Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт”, 2018 онд ГБХЗХГ-аас “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал”, 2019 онд Монголын Эмэгтэйчүүдийн Сан, ДХИС, Хүйсийн Тэгш Эрхийн Төв төрийн бус байгууллагаас “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс”, УЕПГ-аас “Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл”, 2020 онд Нээлттэй нийгэм форумын захиалгаар ДХИС-иас “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааг тус тус хийжээ.

Дээрх судалгаанууд нь цахим гэмт хэрэг, хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоосон боловч тухайлан цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоогоогүй учир энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тусгайлан судлах шаардлагатай гэж үзэн, тус судалгааг 2020 оны 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго, зорилт

Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлэхэд тус судалгаа нь зорино.

Судалгаа нь дараах зорилтуудтай:

1. Цахим орчин дахь гэмт явдлаас хүүхдийг хамгаалах эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх;
2. Цахим хэрэглээнд хүүхэд донтох эрсдэл болон эмгэг, түүний шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
3. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
4. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчин үеийн хандлагын талаар харьцуулан судлах зэрэг болно.

Судалгааны арга зүй

Судалгааны ажилд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэсэн. Тухайлбал, баримт бичигт дүн шинжилгээ хийх¹⁴, нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийх, тохиолдол шинжлэх, ярилцлага хийх, санал асуулга явуулах, контент шинжилгээ хийх, ажиглалт хийх зэрэг аргыг ашигласан. Мөн санал асуулгын судалгааны үр дүнг SPSS-25.0 программ ашиглан боловсруулав. Судалгааны тоон мэдээллийн хувьд сүүлийн 5 жилийн дата өгөгдөлд суурилан дүн шинжилгээ хийсэн ба чанарын судалгааны тухайд өнөөгийн байдлаар хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагаа, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны хязгаарлалт

Судалгаанд дараах хязгаарлалтууд байсныг дурдах шаардлагатай.

- Манай улсад цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, түүний дотор хүүхэд хохирсон, холбогдсон гэмт хэргийн талаар нэгдсэн, нарийвчилсан бүртгэл хангалттай байдаггүй тул дээрх судалгаа нь зөвхөн сүүлийн 5 жилд бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн болно.
- Гэмт хэргийн мэдээлэл, бүртгэлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цахим орчинд гэмт хэрэг үйлдсэн, ялангуяа хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээдүүдийн гэмт хэргийн сэдэл, шалтгаан нөхцөл болон зан үйлд дүн шинжилгээ хийх боломж гараагүй.
- Шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээллээс үзэхэд цахим орчинд хүүхэд хохирсон талаар нарийвчилсан тоон мэдээлэл, судалгаа байхгүй байсан тул дүн шинжилгээ хийх боломжгүй байсан.

¹⁴Судалгаанд ашигласан мэдээлэл нь шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, мэдээллийн технологи, харилцаа холбоо, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээлэл, ажлын тайлан, мөн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны тайлан, материалд үндэслэсэн боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад цахим орчинд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай бие даасан хууль тогтоомж байхгүйгээс гадна, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад ч зохицуулалт хангалтгүй байна. Тус судалгааны хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулиудад дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал, УИХ-аас 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай, 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталж, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан. Мөн УИХ-аас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хүүхдийн эсрэг гэмт хэргийг бие даасан бүлэг болгон, 2016 онд шинэчлэн баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтуудыг тус тус хуульчилсан.

Хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт, бэлгийн мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр манай улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон дэлхийн 49 дэх орон болсон.¹⁵ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд болон эдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

1.1. Эрүүгийн хууль

Эрүүгийн хууль /2002 он/-д заасан цахим гэмт хэргийг 2015 оны шинэчилсэн найруулгаар гэмт хэргийн шинжийг шинээр тодорхойлсон бөгөөд цахим болон бодит орчинд хүүхдэд садар самуун явдлыг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харилцаанд орохыг санал болгох үйлдэл хийсэн; Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан зэрэг үйлдлийг гэмт хэрэг гэж хуульчлан оруулжээ.¹⁶

Эрүүгийн хуулийн 16.8 болон 16.9-д хүүхдийг садар самуунд уруу татах, ашиглахыг хориглосон заалт байдаг ч садар самуун явдал гэсэн ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүйн дээр цахим орчинд хүүхдийг садар самуунд оролцуулах, уруу татах, ашиглах болон бодит хүүхдийг оролцуулаагүй ч

¹⁵ Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

¹⁶ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. /Сургагч багш нарт зориулсан гарын авлага/. 2017 он

хүүхдийн дүрсийг дуурайлгасан зохиомол дүрийг садар самуунд талаар тусгайлсан заалт оруулаагүй байна. Түүнчлэн, цахим орчинд хүүхэд уруу татах, холбоо тогтоох, урхихдах, цахим орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэхээр дарамтлах гэх зэрэг бусад нарийн асуудлуудыг хуульчилж, зохицуулаагүй байна.

Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр насны хязгаар заасан байдаг ч арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн “.. 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/ гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн зохицуулалт байдаг бөгөөд цагдаагийн байгууллага, шүүхийн мэдээллээс үзэхэд судалгааны ажлын хамрах хугацаанд эдгээр төрлийн гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн 14-16 хүртэл насны хүн байхгүй байна.

Өмнө нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуульд 8 төрлийн онц хүнд гэмт хэргийн субъект 14 наснаас байхаар зааж байсан бөгөөд харин 2015 оны шинэ Эрүүгийн хуульд насны онцлогоос хамааран хүүхдийн үйлддэг дээрх төрлийн цахим хэргийг нэмж тусгасан байна. Эрүүгийн хуулийн Наймдугаар бүлэгт өсвөр насны хүмүүст аль болох хорих ял оногдуулахгүйгээр ялын уян хатан бодлогоор нийгэмшүүлнэ гэж тодорхойлжээ.

Монгол Улсын хэмжээнд 2015-2019 онд Эрүүгийн хууль (2002)-ийн 25 дугаар бүлэг компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Эрүүгийн хууль (2015)-ийн 13.10 дугаар зүйлд хувь хүний нууцад халдах, 13.11 дүгээр зүйлд хувь хүний нууцыг задруулах, 18.8 дугаар зүйл хүүхдэд садар самууныг сурталчлах, 16.9 дүгээр зүйл хүүхэд оролцуулж, садар самууныг сурталчлах, 18.17 дугаар зүйл зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, 26 дугаар бүлэг цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 49 хүнд холбогдох 33 хэргийг хүлээн авснаас 31 хүнд холбогдох 23 хэргийг хянан шийдвэрлэж, ял шийтгэл оногдуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

2015-2019 онд цахим орчинд 43 хүүхэд хохирсон¹⁷. Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэгт 2015-2019 онд нийт 20 хэрэгт 15 хүнийг яллагдагчаар татсан байна¹⁸. Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл, залилах гэмт хэрэгт 6, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт 7, хүчиндэх гэмт хэрэгт 1, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт 1 хүнийг яллагдагчаар татжээ. Эдгээрийн 4 нь 18 хүртэлх насны хүмүүс байх ба хүүхдийг биеийг үнэлүүлж ашиг олсон гэмт этгээдүүдийн 1 нь оюутан, нөгөө нь кузов засварчин, 2 нь сурагч байсан байна.

1.2.Зөрчлийн тухай хууль

¹⁷ ЦЕГ-ын мэдээлэл, судалгаа.

¹⁸ ШЕЗ-ийн мэдээлэл, судалгаа.

Тус хуулийн 6.20 дугаар зүйл (хүүхдийн эрхийг зөрчих)-д хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийг хамааруулсан бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд шийтгэл оногдуулахаар заажээ. Тухайлбал, хүн, хуулийн этгээд нь хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан, өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан; амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдэгдэх, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд торгох шийтгэл оногдуулахаар заасан. Зөрчлийн хуульд хүүхдийн эрхийн зөрчилд оногдуулах зөрчлийг тодорхойлон заасан ч цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн шинжтэй зохицуулалтуудыг нарийвчлан заагаагүй байна. Тиймээс зохицуулалт тодорхойгүй тул зөрчил мэдээлэгдэхгүй өнгөрөх эрсдэлтэй байх болохоор харагдаж байна. Цагдаагийн байгууллагын мэдээлэл, судалгаанаас үзэхэд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлээр 2015-2019 оны хооронд нийт 860 зөрчил бүртгэгдсэнээс 820 хүнийг 48.0 сая төгрөгөөр торгох, 3 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нараас цахим орчинд үйлдэгдсэн энэ төрлийн 4 хэргийг торгож шүүхээс шийдвэрлэсэн байх ба одоогийн байдлаар зөрчил шалган шийдвэрлэх ур чадварыг сайжруулах алхмууд хийж эхлээд байна.

1.3.Хүүхдийн эрхийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талын харилцааг зохицуулахад орших бөгөөд хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчлэхээр заажээ.

1.4.Садар самуунтай тэмцэх тухай хууль

Энэхүү хуульд эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журмыг хуульчилсан байдаг. Эротик хэвлэл, дүрс бичлэгийг аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон тусгай цэгт худалдах бөгөөд албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс, барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар, гар дээрээс 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах зэргийг хориглосон байдаг. Одоогийн байдлаар энэ төрлийн харилцаатай холбоотой гарсан асуудлыг Зар сурталчилгааны тухай хууль, мөн

түүнд хамаарах Зөрчлийн тухай хуульд заасан “Зар сурталчилгааны тухай хууль зөрчих” гэсэн зөрчлөөр торгож шийтгэж байгаа ажээ.

1.5.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Уг хуульд “Цахим, цахим орчин, олон нийтийн цахим сүлжээ ашиглаж” гэх тодотголтой нэр томъёо ороогүй хэдий ч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, үндсэн зарчим, үндсэн чиглэл, ажлын төрөл, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх үүрэг гэх зэрэг онцлог талуудыг хуульд тусгажээ.

1.6.Хүүхэд хамгааллын тухай хууль

Тус хуулийн 8-р зүйлд хэвлэл мэдээлэл, цахим орчинд “Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална” гэж гэр бүл, сургууль, болон хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээдүүд хүүхдийг хэрхэн хамгаалах үүрэгтэйг хуульчлан зохицуулсан байдаг. Ингэхдээ хүүхдэд зориулсан цахим агуулга контент нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зааж, хэрэв тус хуулийн заалт зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагыг ерөнхийлөн заасан боловч процедурын шинжтэй нарийвчлан оруулаагүй байна.

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалттайгаар хэрэгжүүлэх салбар дундын байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 218 дугаар тушаалаар байгуулсан. УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 4 дүгээр тогтоолоор Хүүхдийн төлөө үндэсний газрыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болгон шинэчлэн зохион байгуулж улсын хэмжээнд нийслэл, 21 аймагт ГБХЗХГ, 9 дүүрэг тус бүрт хэлтэс байгуулагдсан нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг хамгаалахад чухал алхам болсон.

ГБХЗХГ-ын дэргэд “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор байгуулж, сард дунджаар 10 мянга гаруй дуудлага хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн, хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, Зөрчлийн тухай хуульд заасан хүүхдийн эсрэг 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллах хүүхдийн эрхийн улсын байцаагчийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт заасны дагуу сонгон шалгаруулж,

сургалтад хамруулан эрх олгож, хүүхдийн эрхийн зөрчилтэй тэмцэж байна. Одоогоор зөрчлийн тоо мэдээ байхгүй ч 4 тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэл явуулж торгож шийджээ. Цагдаагийн байгууллагад хүүхдийн хэргийг шалгах зорилгоор 600 алба хаагчаар орон тоог нэмэгдүүлсэн. Мөн Мөрдөн байцаах албанд Хүүхдийн хэлтэс байгуулсан зэргийг дурдаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ, ЦАХИМ ОРЧИН

2.1. Монгол Улс дахь цахим хэрэглээний төлөв байдал

2019 оны байдлаар Монгол Улс нийт 3.25 сая хүн амтай 68.0% нь хот суурин газар оршин суудаг. Монгол Улсад нийт 4.42 сая гаруй гар утас ашиглагддаг бөгөөд 2.2 сая интернет болон нийгмийн сүлжээнд хэрэглэгчтэй¹⁹ байна. Өөрөөр хэлбэл, манай орны 10 хүн тутмын гуравт нь 2 гар утас ногдож байна. Нийт гар утасны хэрэглээний 84% нь урьдчилсан төлбөрт үйлчилгээ ашигладаг бол 16% дараа төлбөрт үйлчилгээг ашигладаг.


Зураг1. Гар утас ашиглалтын мэдээлэл



Нийт гар утасны 78.1% нь “Android” үйлдлийн системтэй, 21.6% нь “Apple Ios” үйлдлийн системтэй байна. Үндэсний статистикийн хорооноос 2020 оны 03 дугаар сарын 09-ний байдлаар Монгол Улсад интернет хэрэглэгч 5.450.609, 3G хэрэглэгч 3.190.595, LTE хэрэглэгч 1.956.8009, суурин интернет хэрэглэгч 303.200 байна гэсэн статистик судалгааг гаргасан байна.

¹⁹ Datarepotal.com 2019 оны тайлан

Зураг2. Монгол Улсын интернет хэрэглэгч



Мөн 2020 оны 03 дугаар сарын 09-ний байдлаар Монгол Улсад интернет үйлчилгээ үзүүлэгч байгууллага 64, Интернет кафе 338, 1000 хүнд ногдох компьютер 208 гэсэн судалгааг²⁰ тус тус гаргасан.

Зураг 3. Монгол Улсын интернетийн үйлчилгээ үзүүлэгч



²⁰ Эх сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_1300_010V6

Улсын хэмжээнд нийгмийн сүлжээг идэвхтэй хэрэглэгч 2.1 сая байна. Нийслэлийн иргэдийн 84%, орон нутгийн иргэдийн 77% нь фэйсбүүк хэрэглэдэг. Ухаалаг гар утасны хэрэглээ 80% болж нэмэгдсэн. 14-21 хүртэлх насны залуус ажлын өдрийн 6 цагийг сошиалд зарцуулдаг²¹ гэсэн судалгаа гарсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Сургалт, судалгаа мэдээллийн төвөөс 2018 онд гаргасан “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан²²”-д “Өсвөр үеийнхний 92% нь интернет хэрэглэдэг, харин хэрэглэдэггүй гэсэн хариултын дийлэнх 76%-ийг орон нутгийн хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд үүнд 11-12 насныхан зонхилж байна.

2.2.Цахим орчноос хүүхдэд учрах эрсдэл

Монгол Улсын хувьд хүн амын 68.0% нь нийгмийн сүлжээ ашигладаг бөгөөд үүний дийлэнх нь хүүхэд байна.²³ Интернет үйлчилгээ авдаг өрхийн хүүхэд нийтийн сүлжээнд холбогдох боломжтой ба өөрсдийн нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг, мэдээлэлгүйгээс эрсдэл нэмэгддэг. Хүүхдэд учрах эрсдэлийг тусгайлан судалж үзэхэд²⁴ насанд хүрэгчдээс хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлж байгаа цахим орчны хэрэглээнд хяналт тавьж, сургууль, гэр бүлийн орчинд хамтран ажиллах шаардлагатай нь ажиглагдсан.

Хүснэгт 1. Эрсдэл

№	Хүчин зүйлс	Интернет орчин	Соёл, гадны соёлын нөлөөлөл	Сэтгэхүйн төлөв байдал	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Хүүхдийн хүмүүжил ба зан суртахуун
1	Интернет орчин	0.682				
2	Соёл, гаднын соёлын нөлөөлөл	0.656	0.654			
3	Сэтгэхүйн төлөв байдал	0.539	0.607	0.724		
4	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	0.634	0.659	0.505	0.608	
5	Хүүхдийн хүмүүжил ба зан суртахуун	0.552	0.494	0.534	0.573	0.721

²¹ <http://dima.mn/2020/01/14>

²² ГБХЗХГ, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан - 2018 он

²³ <https://www.internetworldstats.com/>

²⁴ “Хүүхэд, залуучуудын хүмүүжил, сэтгэхүйн доройтол ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернет орчны хор уршиг судалгааны тайлан”. ДХИС-ийн зарим эрдэмтэн, судлаачдын 2020 онд явуулсан судалгааны тайлангийн хэсгээс.


Судалгааны багаас хийсэн асуулгад хамрагдсан²⁵ хүүхдийн 80% нь гар утас ашиглан цахим орчинтой холбогддог гэсэн ижил үр дүн гарсан ба дараах таван төрлийн сошиал платформын хэрэглээг хүүхдүүдээр өөрсдөөр нь үнэлүүлэхэд:

- Facebook-н хэрэглээ >90%
- Tik tok-н хэрэглээ 60-89%;
- Youtube-н хэрэглээ 40-59%;
- Integramm-н хэрэглээ <20% үнэлсэн.

Цахим орчинг хүүхдүүд ямар зорилгоор ашигладаг, эцэг, эхчүүд хүүхдүүдээ цахим орчинд юу хийж байдаг тухай төсөөллийг харьцуулан харахад дараах үр дүнг гарсан. Үүнд:

- Тоглох, бусадтай харилцах, бичлэг, кино үзэхэд ашигладаг гэдэгт санал нэг байна.
- Харин тоглох, бусадтай харилцах гэсэн хувилбар дээр хувийн зөрүү их байна. Эцэг, эхийн хувьд хүүхдүүд тоглох зорилготой гэж үзэж байхад, хүүхдүүд хэн нэгэнтэй харилцах зорилгоор ашигладаг гэж хариулсан байна.

График 1. Цахим хэрэглээний зорилго



Хүүхдүүдийн фэйсбүүкийн найзын тоо дунджаар 705, нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 25% нь 201-500 найзтай, 23% нь 501-1000 найзтай гэсэн хариулт өгсөн. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 1/3 нь ямар нэгэн хаалттай группд байдаг гэж хариулсан. Хүүхдүүд ихэнх нь өөрсдийнх нь нэвтэрдэг цахим хуудсан дахь мэдээллийн өнгө аясаа эерэгээр үнэлсэн ч гурван хүүхэд тутмын нэг нь “Сөрөг” мэдээлэл байдаг гэж хариулжээ. Мөн цахим орчинд байдаг дараах мэдээллүүдээс аль нь сөрөг/муу мэдээлэл болохыг тодруулахад “Танилцах зар”, “Садар самууны агуулга бүхий мэдээлэл”, “Мэргэжлийн бус хүний зөвлөгөө LIVE”, “Гэмт хэргийн талаарх мэдээлэл” гэсэн хариултыг хамгийн их сонгосон байна.

²⁵ Судалгааны багаас цахим орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 20 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 1699 хүүхэд, 1627 эцэг, эхийг хамруулсан судалгааны дүнгээс.

График 2. Цахим орчин дахь сөрөг мэдээлэл




Интернетийн байгууллага хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрээгүй хүн байгаа эсэхийг огт асуугаагүй гэж эцэг, эхчүүдийн 85% нь хариулсан нь интернетийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд шүүгч программ хангамжаар үйлчлэх хууль, журмаар²⁶ хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, асран хамгаалагчдад тайлбарлаж таниулах байдал маш хангалтгүй байгаа нь илэрхий байв. Мөн ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл технологийн хичээлийн хөтөлбөрийг²⁷ сайжруулах шаардлагатай байна. Учир нь хүүхдүүд анх интернет ашиглахыг 84.5% нь өөрөө болон найз нөхдөөсөө, 11.3% нь эцэг эхээсээ, 4.3% нь хичээлээр энэ талын мэдлэгийг олж авсан гэж хариулжээ.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 40.0% нь цахим орчинд ямар төрлийн мэдээллийг бусадтай хуваалцах нь зохимжтой байдаг талаар мэддэг гэж хариулсан байна. Түүнчлэн, 3 хүүхэд тутмын нэг нь хувийн мэдээллээ нууцлах тохиргоог огт мэдэхгүй бөгөөд сошиал медиагаар танихгүй хүнтэй танилцаж байсан, 5 хүүхэд тутмын 1 нь найзын хүсэлт авахдаа танихгүй хүнийг найзаараа нэмдэг, 4 сурагч тутмын нэг нь үе тэнгийн найз нөхдөө шоолж, цахим орчинд дүрс бичлэг оруулж байжээ.

²⁶ Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам".


²⁷ Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Хөтөлбөр батлах тухай" 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/492 дугаар тушаал.

График 3. Цахим орчинд ямар мэдээлэл оруулах нь аюулгүй болох талаарх ойлголт



Эцэг, эхчүүдийн 40.3% нь цахим орчинд ямар төрлийн мэдээлэл оруулах тухай эрх бүхий байгууллагын гаргасан мэдээлэлтэй танилцаж байгаагүй бөгөөд 64.2% нь хүүхэд цахим орчин дахь сөрөг зүйлээс хамгаалагдаагүй гэжээ. Эцэг, эхчүүдийн 80 орчим хувь нь хүүхдийнхээ интернетийн хэрэглээнд их, бага хэмжээнд хяналт тавьдаг гэсэн хэдий ч тэдний 95 орчим хувь нь цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй, 40% нь цахим орчинд хувийн мэдээллээ нууцлах тохиргооны мэдлэг огт байхгүй байна. Түүнчлэн, хүүхэд нь цахим хүчирхийлэлд өртвөл 92% нь гэрийнхэндээ энэ тухайгаа хэлдэг гэж эцэг, эхчүүд хариулсан хэдий ч энэ асуултыг хүүхдээс өөрөөс нь асуухад дөнгөж 36% нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хэлнэ гэж хариулжээ. Энэ нь цахим орчинд аливаа хүчирхийлэлд өртсөн 3 хүүхэд тутмын 1 нь болсон явдлыг эцэг, эхдээ хэлдэг болохыг харуулж байна.

График 4. Эцэг, эхийн төсөөлөл, мэдлэг



Садар самууныг сурталчилсан, уруу татсан, өдөөн хатгасан үйлдэлд хүүхдүүд хэр өртөж байгааг тандаж асуухад хүүхдүүдийн 18.4% нь цахим орчинд үл таних хүнтэй танилцаж, уулзаж байсан. Хэн нэгэн хүнээс үзэн ядсан, заналхийлсэн, доромжилсон утга, агуулга бүхий мэдээлэл огт авч байгаагүй гэж 74.6% нь, хэд хэдэн удаа авч байсан гэж 55.8%, байнга гэж 2.6% нь хариулсан байна.


Мөн нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 14.6% нь хүчирхийлэл, басамжлал, садар самуун үйлдэл хийхийг шаардсан нөхцөл байдалд орж байсан, 13.8% нь хэн нэгэн хүн над руу садар самуун агуулга бүхий бичлэг, зураг илгээж байсан гэж хариулжээ.

Хүснэгт 2. Садар самуун агуулга бүхий мэдээлэл хүлээн авсан эсэх

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Үл таних хүнтэй танилцаж уулзсан уу?	Тийм	313	18.4%
	Үгүй	1386	81.6%
Та хэн нэгнээс үзэн ядсан, заналхийлсэн, доромжилсон утга бүхий мэдээлэл авч байсан уу?	Байнга	44	2.6%
	Хэд хэдэн удаа	387	22.8%
	Огт үгүй	1268	74.6%
Хэн нэгэн хүчирхийлсэн, басамжилсан, садар самуун агуулгатай үйлдэл хийхийг шаардаж байсан эсэх	Байнга	30	1.8%
	Хэд хэдэн удаа	218	12.8%
	Огт үгүй	1451	85.4%
Хэн нэгэн танд садар самуун агуулга бүхий бичлэг, зураг илгээж байсан эсэх	Тийм	234	13.8%
	Үгүй	1465	86.2%

Эцэг, эхчүүдээс авсан судалгаагаар “Таны хүүхэд интернет, гар утсаа ашиглаж дуусмагцаа сэтгэл санаа нь тогтворгүй болж байсан тохиолдол бий юу?” гэсэн асуултад 19% нь “Тийм” гэж хариулсан бөгөөд чухамхүү юунаас болж сэтгэл санаа нь тогтворгүй болж байсныг тодруулахад 36.8% нь “Тоглоом”, 29.2% нь “Сөрөг бичлэг, кино”, 21.5% нь “Бусадтай харилцаж” гэж хариулсан байна²⁸.

График 5. Сэтгэл санаа тогтворгүй болсон шалтгаан



²⁸ ГБХЗХГ, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан - 2018 он

Олон улсын судалгаагаар өсвөр насны хүүхдүүд өдөрт 15-45 минут интернет ашиглах, тоглох нь зохистой²⁹ гэж зөвлөсөн ба энэ жишгээр авч үзвэл, бараг хоёр хүүхэд тутмын нэг нь интернетийг зохистой хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж байна гэж үзэж болно. Фэйсбүүк хэрэглэдэг гурван хүүхэд тутмын нэг нь хоёр ба түүнээс дээш хаягтай байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Түүнчлэн, 5 хүүхэд тутмын 4 нь зүй бус утгатай зурвас имэйл фэйсбүүкийн хэрэглэгчээс авч байсан, 2 хүүхэд тутмын 1 нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулжээ.

Түүнчлэн, 10% нь цахим тоглоом тоглох зорилгоор интернет ашигладаг гэж хариулсан ба 2013-2017 онд СЭМҮТ-д 281 хүүхэд цахим тоглоомд донтож эмчлүүлсний дийлэнх нь хөвгүүд байна. Цахим тоглоомд донтох асуудал нь эцэг, эхийн хараа хяналт дутмаг байдлаас гадна хүүхэд, залууст чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх газар хомс байгаатай холбоотой гэж үзэж болно. Сурагчдын 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цаг, 30% нь 2 ба түүнээс дээш цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба тэдэнд аливаа асуудал тулгарахад ихэнх тохиолдолд хамгийн дотнын туслагч нь найз нөхөд, үе тэнгийнхэн байна.

Багш, нийгмийн ажилтнууд цахим орчны зохисгүй хэрэглээний талаар 10 сурагч тутмын 1 нь байнга зөвлөгөө авдаг, 2 сурагч тутмын нэг нь заримдаа зөвлөгөө авдаг гэж хариулсан хэдий ч гурван багш тутмын нэг нь өөрийгөө энэ талын зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар байхгүй гэж үнэлсэн байна. Мөн ерөнхий боловсролын сургуульд өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдэлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал 75 гаруй хувьд нь байхгүй гэж үзсэн. Цаашид өсвөр насныхны хувьд цахим орчин нь нэгэнт хэрэглээ болсон тул шууд хязгаарлахаас илүүтэй ухаалаг хэрэглээг зүй зохистой хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа хийх, сургалтын хөтөлбөрт тусгах, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад цахим хэрэглээ, сэтгэл зүйн зөв дадал, ухаалаг хэрэгцээний талаар сургалт, үйл ажиллагааг хөтөлбөрөөр оруулах, сөрөг мэдээллийг шүүгч программ хангамжийн мэдлэгийг олон нийтэд, оновчтой сувгаар тогтмол олгох нь үр дүнтэй гэж холбогдох байгууллагаас үзжээ.³⁰

²⁹ ГБХЗХГ, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан - 2018 он


³⁰ ГБХЗХГ, Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан - 2018 он

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, НӨХЦӨЛ

3.1. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг

Судалгааны хүрээнд хүүхэд гэмт хэргийн халдлагад өртөж хохирсон талаарх цагдаагийн байгууллагын тоон мэдээнд дүн шинжилгээ хийлээ. Улсын хэмжээнд 2015-2019 онд 154690 гэмт хэрэг бүртгэгдсэний 7565 буюу 4.9%-ийг хүүхэд хохирсон гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд нийслэлд 4825, орон нутагт 2738 бүртгэгдсэн байна.


График 6. Хүүхэд хохирсон гэмт хэрэг



Хүүхэд хохирсон гэмт хэрэг 2019 онд 1554 бүртгэгдэж 2018 оноос 9.9%-аар өсч, 2018 онд бүртгэгдсэн хэрэг 2017 оноос 22.0%-аар, 2017 онд бүртгэгдсэн хэрэг 2016 оноос 0.4%-аар тус тус буурсан бол 2016 онд бүртгэгдсэн хэрэг 2015 оноос 6.6%-аар өссөн байна.

Үүнийг цааш нарийвчлан судалж үзвэл 2015-2019 онд цахим орчинд 1749 гэмт хэрэг бүртгэгдсэний 43 буюу 2.5% нь хүүхэд хохирсон байна. Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэргийг бүртгэгдсэн оноор нь авч үзвэл, 2015 онд 2, 2016 онд 1, 2017 онд 1, 2018 онд 12, 2019 онд 27 бүртгэгдсэн. Энэ тоон үзүүлэлт бол зөвхөн бүртгэгдэж, ил гарсан гэмт хэрэг гэдгийг энд онцлохыг хүсч байна.


График 7. Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэг



Энэ төрлийн гэмт хэрэгт сүүлийн 5 жилийн байдлаар нийт 226 хүнийг 670 хэрэгт холбогдуулан шалгасны 2015 онд 50 хүнийг 53 хэрэгт, 2016 онд 38 хүнийг 54 хэрэгт, 2017 онд 27 хүнийг 63 хэрэгт, 2018 онд 42 хүнийг 157 хэрэгт, 2019 онд 69 хүнийг 343 хэрэгт тус тус холбогдуулан шалгасан байна.

Харин 2016 онд сэжигтнээр татсан хүнийг 2015 онтой харьцуулбал 24.0 хувиар, 2017 оны сэжигтнийг 2016 онтой харьцуулбал 28.9 хувиар тус тус буурч, 2018 онд тухайн хэрэгт холбогдогчдыг 2017 оныхтой харьцуулбал 55.6 хувиар, 2019 оны холбогдогчдыг 2018 онтой харьцуулбал 64.3 хувиар тус тус өссөн байна.

График 8. Гэмт хэрэг тоо, 2015-2019 он



Бүртгэгдсэн гэмт хэргийн зүйл, ангиар нь авч үзвэл, нийт 9 төрлийн гэмт хэрэгт цахим орчинд хүүхэд хохирсон байх бөгөөд нийт хэргийн 18 буюу 41.9% нь залилах, 14 буюу 32.6% нь хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 2 буюу 4.7% нь заналхийлэх, хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох төрлийн гэмт хэргүүд эзэлж байгаа бол бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, цахим мэдээлэлд хууль бусаар халдах төрлийн гэмт хэрэг тус бүр нэг үйлдэгджээ.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн зүйл, ангиар

Д/д	Төрөл	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	Нийт
1	Залилах	1	1	1	10	5	18
2	Цахим мэдээлэлд хууль бусаар халдах					1	1
3	Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах				2	12	14
4	Заналхийлэх					2	2
5	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах					1	1
6	Хүн худалдаалах					1	1
7	Хүчиндэх					2	2
8	Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох					2	2
9	Бэлгийн мөлжлөг					1	1
	Нийт	1	1	1	12	27	

3.2.Цахим гэмт хэргийн хохирогч хүүхэд

Цахим орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 20 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 1699 хүүхэд, 1627 эцэг, эхээс санал асуулга авч³¹ үр дүнг нэгтгэв.

Судалгаанд оролцсон 1699 хүүхдийн 16.4% (280) нь цахим гэмт халдлагад өртөж байсан гэжээ.

Цахим гэмт хэрэгт өртөж байсан гэх эдгээр хүүхдүүдийн 33.8% нь мөнгө эд зүйлсээ залилуулсан, 19% нь нууц үг хувийн мэдээллээ алдсан, 15.7% нь зодуулж дээрэмдүүлсэн, 12.8% нь садар самуунтай холбоотой гэмт хэрэгт өртөж байсан, 10.2% нь гүтгүүлж, доромжлуулсан, 8.5% нь дарамтад орсон гэж хариулжээ.


График 9. Өртөж байсан цахим гэмт халдлагын төрөл



Цахим гэмт халдлагад өртөж байсан гэж дээр хариулсан 280 (16.4%) хүүхдийн 55(19.6%) нь цагдаагийн байгууллагад хандсан байна. Харин цагдаагийн байгууллагад хандаагүй хүүхдүүд яагаад цагдаад мэдэгдээгүй шалтгаанаа дараах байдлаар (График 10) тайлбарлажээ.


³¹ Энэхүү санал асуулга нь цахим орчны талаарх хүүхдийн ойлголт, хэрэглээ, цахим гэмт хэргийн талаарх эцэг, эхийн мэдлэгийг тодорхойлоход чиглэгдсэн.

График 10. Цахим гэмт халдлагад өртөөд цагдаад хандаагүй шалтгаан




Дээрхээс үзвэл, ямар нэгэн хэлбэрээр цахим гэмт хэрэгт өртсөн талаараа ойр дотнын хүн болон бусад байгууллагад мэдэгдээгүй ажээ. Харин цахим орчинд гэмт хэргийн улмаас нийт 43 хүүхэд хохирсон гэж бүртгэгдсэн ба бүртгэгдсэн оноор нь авч үзвэл, 2015 онд 2, 2016 онд 1, 2017 онд 1, 2018 онд 12, 2019 онд 27 хүн хохирсон байна. 2019 онд хохирсон хүүхдийг 2018 оныхтой харьцуулбал, 2.3 дахин өссөн байна.

График 11. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч /2015-2019/




Хохирогчдыг хүйсээр нь авч үзвэл, энэ хугацаанд нийт хохирогчдын 11 буюу 26.6% нь эрэгтэй, 32 буюу 74.4% нь эмэгтэй хүүхэд байна.

График 12. Хохирогчдын хүйс



Хохирогчдыг насны ангиллаар нь авч үзвэл, нийт хохирогчдын 8 буюу 18.6% нь 12 болон 15, 4 буюу 9.3% нь 13 болон 14, 9 буюу 20.9% нь 16, 10 буюу 23.3% нь 17 насны хүүхдүүд байна.

График 13. Хохирогчдын насны ангилал, хүйс /2015-2019/




Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 22.9 сая төгрөгийн хохирол учирснаас 2015 онд 0.9 сая, 2016 онд 0.4 сая, 2017 онд 0.8 сая, 2018 онд 11.0 сая, 2019 онд 9.8 сая төгрөгийн хохирол учирсан байна. Мөн хүүхдийн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон талаарх нарийвчилсан судалгааг энэ хугацаанд гаргах боломжгүй байв.

3.3.Цахим орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч

Цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэгт 2015-2019 онд нийт 20 хэрэгт 15 хүнийг яллагдагчаар татсан байна.


График 14. Цахим гэмт хэрэг үйлдэгчид оноор



Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл, залилах гэмт хэрэгт 6, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт 7, хүчиндэх гэмт хэрэгт 1, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт 1 хүнийг яллагдагчаар татсан байна.


Хүүхдийн эсрэг цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгааныг ангилан авч үзвэл, тэдний 6 нь буюу 40% нь хялбар аргаар ашиг олох зорилгоор, 5 нь буюу 33.3% нь бэлгийн дур хүслээ хангах зорилгоор, 2 нь буюу 13.3% нь согтуурсан үедээ мөн л бэлгийн дур хүслээ хангах зорилгоор үйлдсэн байхад үлдсэн 2 буюу 13.3% нь хүүхдийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор тус тус үйлджээ. Цахим орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг бэлгийн зүй бус үйлдэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн дийлэнх хувийг гэмт хэрэгтнүүд өөрсдийн бэлгийн дур хүслийг хангах зорилгоор үйлдсэн байхад харин цахим орчинд үйлдэгдсэн залилангийн шинжтэй гэмт хэрэг нь ашиг олох зорилгоор буюу хялбар аргаар мөнгө олох зорилгоор үйлдэгджээ.

График 15. Гэмт хэрэг үйлдэгчдийн насны байдал




Яллагдагчийн боловсролын түвшинг авч үзвэл, 2 яллагдагч боловсролгүй, 2 яллагдагч бүрэн бус дунд, 9 яллагдагч бүрэн дунд, 2 яллагдагч дээд боловсролтой байна.

График 16. Гэмт хэрэг үйлдэгчдийн боловсролын байдал



Тухайн этгээдүүдийн багагүй хувь нь өмнө нь ял шийтгэл эдэлж байсан байна. Харин цахим орчинд хүүхэд хохирсон дээрх гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан ялыг нь авч үзвэл, 3 хүнд холбогдох гэмт хэрэг нь шүүхийн шатанд хэрэгсэхгүй болж, 3 этгээдэд торгох ял, 1 этгээдэд нийтэд тустай ажил хийлгэх ял, 8 этгээдэд 3 сараас 20 жилийн хорих ял оноожээ.

График 17. Гэмт хэрэгтнүүдэд үйлдсэн гэмт хэргийн төрөл, оноосон ял шийтгэл



Тухайн 20 гэмт хэрэгт 15 яллагдагч холбогдсон байгаа бөгөөд 1 этгээд 6 гэмт хэрэгт холбогдсон байна.

Жишээ 1. С гэх этгээд нь 2018 оны 12 дугаар сараас эхлэн 2019 оны 07 дугаар сарыг хүртэлх хугацаанд нийт 6 бага насны охиныг фэйсбүүк орчинд "Анар байна өө" гэх хаягнаас танилцан, улмаар Баянзүрх дүүрэгт байх гэртээ аваачиж удаа дараа бэлгийн харьцаанд орсон. Тухайн этгээдийн хувийн онцлогийг үзэхэд уг этгээд нь багш мэргэжилтэй, улсын нэгэн их сургуульд багшаар ажилладаг, эхнэр, хүүхэдгүй бөгөөд бага насны охидтой танилцаж, дотносож улмаар бэлгийн харилцаанд орох санал тавьж энэ гэмт хэргийг үйлджээ.

Цаашлаад цахим орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн гэмт хэргийн сэдэл шалтгаан болон ажил, мэргэжлийг харьцуулан харвал: бэлгийн дур хүслээ хангах сэдлээр үйлдсэн гэмт этгээдүүдийн 2 нь багш, 2 нь ажилгүй үлдсэн 1 тогооч байхад, согтуурсан үедээ бэлгийн дур хүслээ хангасан этгээдүүд нь жолооч болон ажилгүй байсан бол, хүүхдийг биеийг үнэлүүлж ашиг олсон гэмт этгээдүүдийн 1 нь оюутан, нөгөө нь кузов засварчин байна. Харин хялбар аргаар ашиг олох зорилгоор цахим орчинд залилан хийсэн этгээдүүдийн 4 нь ажилгүй, хоёр нь сурагч байна.

График 18. Гэмт хэрэг үйлдэгчид ба тэдний ажил мэргэжлийн хамаарал



Бэлгийн дур хүслээ хангах сэдлээр гэмт хэрэг үйлдэгчдийн дунд хүүхэдтэй хамгийн ойр ажилладаг багш байгаа нь нэлээд анхаарал татаж байна. Олон улсын туршлагад ч гэсэн ялангуяа бага насны хүүхдийн эсрэг хүчирхийллийг үйлдэгчдийн дунд хүүхдүүдтэй хамгийн ойр ажилладаг багш, спорт дасгалжуулагч, хүүхдийн эмч зэрэг ажил мэргэжилтэй хүмүүс байх нь тохиолдол байдаг бөгөөд ийм төрлийн хүмүүс нь пидифил³² болон эфебофил³³ сэтгэцийн хам шинжтэй хүмүүс байх магадлалтай байдаг байна (Interagency Working Group, 2016).

Хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийг цахим орчинд үйлдэгсэд нь ямар ч ажил мэргэжилтэй, хэн ч байж болох боломжтойг судалгааны үр дүн харуулж байна. Эсрэгээрээ цахим орчинд хүүхдийг залилах, хялбар аргаар ашиг олж буй гэмт этгээдүүдийн дийлэнх нь буюу 4 нь ажилгүй байхад, 2 нь сурагч байна. Өсвөр насны сурагчид ашиг олох зорилгоор цахим орчинд бусад хүүхдүүдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байгааг анхааралдаа авч энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

³² WHO, International Statistical Classification of Diseases and Related Health Problems, 10th revision, 2010, F65.4

³³ Ibid.

3.4.Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг

Монгол Улсын хэмжээнд 2015-2019 онд Эрүүгийн хууль /2002/-ийн 25 дугаар бүлэг компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Эрүүгийн хууль /2015/-ийн 13.10 дугаар зүйлд хувь хүний нууцад халдах, 13.11 дүгээр зүйлд хувь хүний нууцыг задруулах, 18.8 дугаар зүйл хүүхдэд садар самууныг сурталчлах, 16.9 дүгээр зүйл хүүхэд оролцуулж, садар самууныг сурталчлах, 18.17 дугаар зүйл зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, 26 дугаар бүлэг цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 49 хүнд холбогдох 33 хэргийг хүлээн авснаас 31 хүнд холбогдох 23 хэргийг хянан шийдвэрлэж, ял шийтгэл оногдуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Харин 2016 онд энэ төрлийн гэмт хэрэг шүүхээр шийдвэрлээгүй байна. Түүнчлэн 2015-2019 онд хянан шийдвэрлэсэн хэргийг зүйлээр харуулбал:

Хүснэгт 4. Шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл огноогоор

Огноо	2015		2016		2017		2018		2019	
	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн	Хэрэг	Хүн
Эрүүгийн хууль /2002 он/, /2015 он/-ийн тусгай ангид заасан зүйл анги										
13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах									2	2
13.11 дугаар зүйл. Хувь хүний нууцыг задруулах							1	1	1	1
16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах									4	4
16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах										
26.1 дүгээр зүйл. Цахим мэдээлэлд хууль бусаар халдах					2	2	3	4	9	16
26.2 дугаар зүйл. Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах										

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгт 2018 онд 7 хүн, 2019 онд 34 хүн хохирогчоор тогтоогдсон, нийт 8.3 сая төгрөгийн хохирол учирснаас иргэнд 5.2 төгрөгийн, хуулийн этгээдэд 3 сая төгрөгийн хохирол тус тус учирсан байна.

Манай улсад цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх хэрэгцээ шаардлага их байсантай холбоотойгоор ШШҮХ-нд мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд мэргэжилтнээр оролцож ул мөр, эд мөрийн баримт цуглуулах, шинжилгээ хийж дүгнэлт гаргах мэргэжилтэй боловсон хүчин, техник технологиор тоноглогдсон "Гэрэл зураг, дүрс бичлэг-дүр зургийн шинжилгээний лаборатори" үйл ажиллагаа явуулж байна. Харамсалтай нь шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээллээс үзэхэд, цахим орчинд хүүхэд хохирсон талаар нарийвчилсан тоон мэдээлэл, судалгаа байхгүй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАХИМ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

4.1.Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал

Монгол Улсын Засгийн газар, ХЗДХЯ, МУГХУСА33, ЦЕГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ын Хүүхдийн сан, Faro төрийн бус байгууллага хамтран цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2018, 2019 онд “UNFRIEND, “Цахим орчинг зөв болгоё”, “Зөвийг түгээе” аяныг зохион байгуулсан.

Аяны хүрээнд хүүхэд залуусыг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, цахим сүлжээг зөв зохистой хэрэглэх, аюулгүй байдлаа хангах талаар сургалт, соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээх хэлбэрээр зохион байгуулжээ.

“UNFRIEND хөдөлгөөн”-ий тухай:

Цахим орчин дэлхий ертөнцийг холбох гүүр болсон төдийгүй улам бүр хурдацтай хөгжиж байгаа шинэ эриний хүчтэй хэрэгсэл болоод байна. Монгол Улсад интернет хэрэглэгчдийн тоо сүүлийн 4 жилд 40%-иар өсч, 2.9 сая хэрэглэгчтэй болсон төдийгүй фэйсбүүкийн идэвхтэй хэрэглээгээрээ Азидаа 1-т, Дэлхийд 10-т багтаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон интернет орчинд үйлдэгдэж буй бусад төрлийн гэмт хэрэг 2017 онд 299, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 279 бүртгэгдсэнээс харахад цаашид өсөх хандлагатай байна.

Дээрх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, өсвөр насны хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил бусад эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хяналт тавих, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “UNFRIEND хөдөлгөөн”-ийг ХЗДХЯ, ГХУСА33, ЦЕГ хамтран 2019 оны 9 дүгээр сарын 5-аас 25-ны өдөр зохион байгуулсан байна.

Зураг 4. Unfriend хөдөлгөөнд ашиглагдсан зурагт сурталчилгаа



Тус хөдөлгөөний хүрээнд 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Төрийн ордны их танхимд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, оюутан, сурагч зэрэг 800 хүн оролцуулсан “Таны хүүхдийг танихгүй хүмүүс хүмүүжүүлж байна” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжийг Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарт гардуулан өгсөн.

Facebook дэх садар самууныг сурталчилсан болон зохисгүй агуулга бүхий контент агуулсан групп, цахим хуудаснуудыг REPORT хийж, фэйсбүүк компанид мэдээлснээр уг контентыг хэсэгчлэн болон группийг бүхэлд нь устгуулах зорилготой “Хар жагсаалт/Black list” группийг үүсгэсэн. Группэд 19,300 гишүүн идэвхтэй мэдээлж тус группийн үйл ажиллагааг дэмжиж байна.

Unfriend хөдөлгөөнийг өрнүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд, олны танил 150 хүнээр фэйсбүүк дэх ковер, фрэйм зураг солиулж, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд уриалсан пост нийтлүүлэх зэргээр цахим давлагаа өрнүүлсэн.

Зураг 5. Unfriend хөдөлгөөнд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа

Хууль зүй, дотоод хэргийн яам | ЦАГААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР | МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛАГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хууль зүй, дотоод хэргийн яам | ЦАГААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР | МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛАГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

UNFRIEND ХӨДӨЛГӨӨН

UNFRIEND ХӨДӨЛГӨӨН

Интернет орчин дахь өөрийн хувийн мэдээллийн нууцлалд анхаарч, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх

Таны хүүхдийг танихгүй хүн хүмүүжүүлж байна

Та хүүхдээ цахим гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс хамгаалах үүрэгтэй

Дэлгэцийн ард хэн ч байж болно

Өөрийгөө болон найзуудаа эрсдэлээс хамгаалъя

Дэлгэцийн ард хэн ч байж болно

Танихгүй найзуудаа *unfriend/unfollow* хийцгээе

Unfriend Unfollow

UNFRIEND хөдөлгөөнд нэгдэж цахим орчинд зохистой хэрэглээг бий

UNFRIEND хөдөлгөөнд нэгдэж цахим орчинд зохистой хэрэглээг бий

БОЛГОЦГООЁ

БОЛГОЦГООЁ

ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН УТАС: 108

ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН УТАС: 108

Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг агуулга бүхий 15 видео контент бүтээж олон нийтийн цахим

сүлжээгээр түгээснийг давхардсан тоогоор 3.465.293 хүн үзэж, 47.791 хүн бусадтай хуваалцаж, 36.829 хүнд таалагдаж, 2,552 сэтгэгдэл үлдээсэн байна. Дээрх контентуудыг 31 телевизээр түгээснийг 318,720 хүн үзжээ. Анхааруулга, сэрэмжлүүлэг, мэдээлэл бүхий 51 зурагт мэдээг олон нийтийн цахим сүлжээнд нийтэлснийг 813.165 хүн үзэж, 7.142 хүнд таалагдаж, 5.794 хүн бусадтай хуваалцан, 398 сэтгэгдэл үлдээжээ.

Цахим гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхдүүд ихээхэн холбогдож, өртдөг тул тэдний сонирхдог дуучдаар “Unfriend” дуу бүтээлгэн Youtube, Facebook page хуудсуудад байршуулсныг давхардсан тоогоор 813.760 хүн үзэж, 11.510 хүнд таалагдаж, 24.455 хүн бусадтай хуваалцаж, 392 сэтгэгдэл үлдээжээ. Дуу, клипийг олон нийтэд хүргэх зорилгоор 32 радио, 31 телевизэд тараан, цацуулах ажлыг зохион байгуулсан.

Оюутан, сурагчдад зориулж “Цахим орчны талаар таны мэдэхгүй үнэн” сэдэвт хичээл бэлтгэж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын ямаар дамжуулан сургалт зохион байгуулсан бөгөөд уг сургалтад ерөнхий боловсролын 65 сургуулийн 72.751 сурагч, 15 их, дээд сургууль, коллежийн 2385 оюутан хамрагдсан. Оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор их, дээд сургуулиудын дунд чалленж зохион байгуулахад 16 сургууль бүтээл ирүүлснийг олон нийтийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулж, урамшуулсан.

Иргэд, олон нийтэд мэдлэг олгох, хөдөлгөөнийг сурталчлах, өрнүүлэх ажлын хүрээнд 192,603 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж, олон нийтийн газар байршсан 220 LED дэлгэц, томоохон кино театруудаар видео контент түгээж, 88 хулдаасан самбар байршуулсан. Үүрэн телефоны 4 оператороор дамжуулан 2 удаагийн зорилтот мессежийг хүргэн, Univision, Skymedia, DDISH телевизэд хөдөлгөөнийг сурталчилсан баннер байршуулах ажлыг зохион байгуулсан. Мөн 2018 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр “Гэрэлт гудамж”-нд урлагийн оддыг оролцуулан тоглолт зохион байгуулж, залуусыг нэгдүүлсэн.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах хүрээнд 41 телевиз, 9 радиогоор 374 удаагийн нэвтрүүлэг, зочны цаг, хэлэлцүүлэгт алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын албан хаагч нар оролцож, мэдээ, мэдээлэл өгснийг 318,720 хүн үзжээ. Мөн 8 сонинд 24, 76 сайтад 45 мэдээ, мэдээлэл, сурвалжлага нийтлүүлсэн байна.

Цахим орчинг зөв болгоё аяны тухай:

Монгол Улсын Засгийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар хамтран цахим орчинд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор “Цахим орчинг зөв болгоё” ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны аяныг 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 27-ны өдрийн хооронд олон нийтийн сүлжээний facebook, twitter, Instagram орчинд зохион байгуулжээ.

Зураг 6. Цахим орчинг зөв бол Гоё аянд ашиглагдсан зурагт сурталчилгаа



Байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд сошиал, медиагийн 20 видео контент бүтээж телевиз, цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор 4.460.882 хүнд хүрч, 2.367.700 хүн үзэж, 34.748 хүн бусадтай хуваалцаж, 122.062 хүнд таалагдаж, 89.642 эерэг сэтгэгдэл бичсэн байна.

Зураг 7. Цахим орчинг зөв болГоё аянд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа



Мөн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг бүхий 50 бүтээлч постер /зурагт хуудас/ цахим сүлжээнд нийтэлсэн нь 1.073.922 хүнд хүрч, 11.359 хүнд таалагдаж, 4516 хүн бусадтай хуваалцан, 1955 эерэг сэтгэгдэл үлдээсэн байна.

Зөвийг түгээе аяны тухай:

Өсвөр насны хүүхэд, залуусыг цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох, цахим харилцааны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулсан.

Зураг 8. Зөвийг түгээе аянд ашиглагдсан зурагт сурталчилгаа



“Зөвийг Түгээе” хэмээх нэгдсэн аянд Faro Foundation Mongolia төрийн бус байгууллага нь нэгдсэн аяны хэрэгжилт, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа, түүнд ашиглах цахим постер, видео хичээлүүдийг бэлтгэх үүрэг гүйцэтгэсэн.

Нэгдсэн аян 10 дугаар сарын 1-ний өдрөөс 25-ны өдрийг хүртэл амжилттай хэрэгжсэн ба уг хугацаанд 40 цахим постер /Хавсралт 1/, 15 видео хичээлийг нийгмийн сүлжээнд Faro Foundation Mongolia болон Digital Literacy Mongolia цахим хуудсаар олон нийтэд түгээн нийтэлсэн.

Цахим постеруудаар интернет, нийгмийн сүлжээг зөв зохистой хэрэглэх, цахим орчны давуу болон сул талыг таниулан ойлгуулах, өөрийн хувийн мэдээллийг нууцлах, цахим аюулгүй байдлыг сахих, мэдээллийн үнэн зөвийг таних, зөв шүүмжлэлт сэтгэлгээг дэмжих, цахим ертөнц болон нийгмийн сүлжээн дэх эерэг харилцаа хандлагыг хөгжүүлэхэд уриалсан болно.

Зураг 9. Зөвийг түгээе аянд ашиглагдсан зурагт ухуулга сурталчилгаа

Цахим боловсролын хөтөлбөрийн сэдвийн хүрээнд олон нийтэд мэдлэг, мэдээлэл түгээх зорилгоор нийт 18 видео хичээлийг дүрсжүүлэн нийгмийн сүлжээнд нийтэлсэн. Хүний анхаарал төвлөрөх хугацааг харгалзан үзэж дүрс бичлэг тус бүрийн



үргэлжлэх хугацааг 1 минутаас хэтрүүлэхгүй байхаар тооцоолон хийсэн ба олон нийтэд хүргэхийн тулд сонирхолтой зураглалаар дүрсжүүлж, 2D болон график зургийг хослуулсан ба үүндээ олны танил мөн нийгмийн нөлөөлөл бүхий хүмүүсийг оролцуулан тоглуулсан болно.

Аяны хүрээнд Faro Foundation Mongolia нь Цахим боловсролын хөтөлбөрийг олон нийтэд танилцуулснаар “Зөвийг Түгээе” аяны үйл ажиллагааг эхлүүлсэн. ICT EXPO 2019 гурван хоног үргэлжилсэн ба давхардсан тоогоор 500 гаруй хүнд Цахим боловсролын хөтөлбөрийн талаар мэдээлэл хүргэсэн байна.

“Зөвийг түгээе” аяны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа

“Зөвийг Түгээе” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг бий болгох, цахим орчин дахь эерэг харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, цахим аюулгүй байдлыг хангах, аливаад хандах зөв шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх зэрэг олон талт асуудлаар ухуулга, нөлөөллийн ажил хийсэн.

Нөлөөллийн аяны үр дүн, үзэгчдийн хандалт, тэдгээрийн үзүүлж буй хариу үйлдлээс дүгнэн үзэхэд, мэдээлэл дутуугаас болж хувийн нууцлалаа алдах, эх сурвалж нь тодорхойгүй худал мэдээллийг цааш нь түгээх, хэт туйлшрах зэрэг сөрөг асуудлууд нийгмийн сүлжээнд бий болж эргээд өөрсдөө хохирох хандлага их байна.

Олон нийтэд түгээсэн мэдээлэл бүхий контентуудаар цахим боловсролыг таниулан, нийгмийн сүлжээний зүй зохистой хэрэглээг бий болгох, цахим харилцааны эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд том түлхэц болж, амжилттай хэрэгжиж өндөрлөсөн. Аяны үйл ажиллагаатай уялдаа бүхий дагалдах хөтөлбөр, төлөвлөгөөт сургалтууд нь олон нийт хэрхэн хүлээн авч, ач холбогдолтойг ойлгосны үр дүн юм.

Зөвлөгөө хэсэг рүү оруулж болно.

4.1. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гадаадын зарим улсын тогтолцоо, туршлага

WeProtect Alliance – Бид Хамгаална холбоо

Бид Хамгаална (WePROTECT) Дэлхий нийтийн Холбоо нь хүүхдийн эсрэг бэлгийн зүй бус үйлдэл, бэлгийн мөлжлөгийн эсрэг хариу арга хэмжээ авах төрийн болоод хувийн хэвшлийнхний дэлхий нийтийн түншлэл юм. Тус холбоонд одоогийн байдлаар дэлхийн 83 орон, 24 томоохон технологийн компани, НҮБ-ийн Хүүхдийн сан гэх мэт олон улсын байгууллагууд, хүүхдийн эсрэг үйлдэгддэг хүнд төрлийн хүчирхийлэл болох цахим орчин дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийг таслан зогсоох чиглэлээр ажилладаг тэргүүлэгч 20 иргэний нийгмийн байгууллагууд байна.

Монгол Улс энэ холбоонд 2017 онд гишүүнээр элссэн.³⁴ Холбооны гишүүн улс бүр нь Бид Хамгаална үндэсний загварын хүрээнд: Бодлого ба Засаглал, Хуулийн хэрэгжилт, Хохирогч, Нийгмийн хүчин зүйл, Хувийн хэвшлийн оролцоо, Хэвлэл мэдээлэл ба Харилцаа холбоо гэсэн 6 дэд чиглэлийн хүрээнд цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилладаг. Манай улс үндэсний загвар хариу арга хэмжээ авах энэ ажлын хүрээнд ХНХЯ-р ахлуулсан, салбар дундын ажлын хэсэг байгуулан 2018 оноос хойш ажиллаж байна.

Бусад орны туршлага

Хүүхэд хамгааллын тогтолцоо нь хүний нөөц, санхүү, хууль тогтоомж, бодлого боловсруулах, засаглал, хяналт, мэдээлэл цуглуулах, хамгаалах, хариу арга хэмжээ авах, асрамж, халамжийн үйлчилгээний менежмент бүхий бүрэлдэхүүн хэсгээс бүрдүүлдэг. Хүүхэд хамгааллын тогтолцооны амин чухал асуудал нь эдгээр оролцогчдын хоорондын харилцаа, хамтран ажиллах процесс гэж үздэг³⁵ байна.

Судалгаанд хамрагдаж буй орнуудыг хүүхдийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй чиглэлээр үйл ажиллагаа эрх зүйн бүлгээс хамааран сонгон авсан болно. Холбооны болон нэгдсэн тогтолцоотой улсуудад холимог тогтолцоотой хүүхэд хамгааллын бодлого хэрэгжиж байгаа нь ихээхэн сонирхол татаж байгаа байна.


а) Канад Улс: Хүүхдэд чиглэсэн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, мөрдөн байцаах ажиллагааны журам, хөндлөнгийн оролцооны мандатыг тодорхойлсон журам муж бүр мэдэгдэхүйц ялгаатай байгаа ч эдгээр тогтолцоо нь нийтлэг нэг шинж чанартай, түүний дотор хүүхдийн хүчирхийлэлд өртсөн, үл

³⁴ Joint Directive #A/37, /61, A/67 of the Head of Communication and Information Technology Authority, the head of the Authority for Family, Child and Youth Development and the Chairman of the Communications Regulatory Commission, March 22, 2018 establishing the working group.

³⁵ ЮНИСЕФ / НҮБ-ын Хүн амын хөгжлийн хөтөлбөр/ Дэлхийн зөн, 2013, хуудас 3).

хайхарсан, хүчирхийллийн аливаа хэлбэрийн тухай мэдээлэх зэргийг багтаасан байдаг. Канад улс нь хүүхэд, гэр бүлийнхний эсрэг аюулгүй чиг баримжаа бүхий үйл ажиллагааг хүүхдийн хамгааллын тогтолцоо гэж тодорхойлдог байна.³⁶

Зураг 10. Канадын хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоо



Тус улс нь хүүхэд хамгааллын тал дээр иргэдээсээ санал, шүүмж болон туршлага, мэдээлэл авах зорилгоор support@protectchildren.ca хаягыг ашигладаг. Түүнчлэн “Online safety” уриагаар хүүхэд,³⁷ эцэг эхчүүд, залуучуудад³⁸ зориулсан цахим аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах болон бусад эрсдэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаар авдаг байна.

Канад Улс нь хүүхдийн цахим халдлагатай хамгийн сайн тэмцэх алхам бол эцэг, эхийг нь мэдээллээр хангах явдал гэж үздэг. Тиймээс тус улс нь эцэг, эхчүүдэд туслах “Protectkidsonline”³⁹ цахим хуудсыг ашиглан эцэг, эхчүүдэд “Online safety” хэмээх уриалгын дагуу мэдээллээр хангаж ажиллаж байна. Энэхүү цахим хуудас нь цахим эрсдэл, цахим халдлага зэргийг эцэг, эхчүүдэд таниулах, болзошгүй эрсдэлийг тэдний өмнөөс тооцоолж шаардлагатай арга хэмжээний талаарх зөвлөгөөг оруулж өгсөн байгаараа онцлогтой юм.

³⁶https://www.mcgill.ca/crcf/files/crcf/2018_-_national_systems_of_child_protection_springer_chapter_3.pdf

³⁷<http://zoeandmolly.ca/>

³⁸<https://needhelpnow.ca/>

³⁹<https://protectkidsonline.ca/>


Хүснэгт 5. Өртөж болзошгүй халдлага насны бүлгээр

Нас	5-7 насны хүүхдүүд	8-10 насны хүүхдүүд	11-12 насны хүүхдүүд	13-15 насны хүүхдүүд
Өртөж болох халдлага	Бичлэг эсвэл тоглоом үзэж байхдаа зар сурталчилгаа, холбоос, санал болгосон видео тоглоом дээр дарснаар тоглоом, видеон доторх зохисгүй контентэд орох боломжтой.	Кибер халдлага - онлайн дарамт	Кибер халдлага - онлайн дарамт	Кибер халдлага - онлайн дарамт
		Насанд хүрэгчтэй цахим харилцаа үүсгэх	Насанд хүрэгчтэй цахим харилцаа үүсгэх	Насанд хүрэгчтэй цахим харилцаа үүсгэх /бэлгийн дарамтад орох/
		Бэлгийн харилцааг сурталчилсан дүрс, бичлэг	Бэлгийн харилцааг сурталчилсан дүрс, бичлэг	Бэлгийн харилцааг сурталчилсан дүрс, бичлэг
				Секстинг ⁴⁰ Нүцгэн зургыг нь олон нийтэд түгээх

б) ХБНГУ: Хүүхэд хамгааллын тухай тодорхой заалтыг тусгаагүй боловч тус улсын Иргэний хуульд (§1666 BGB) заасан "Хүүхдийн сайн сайхан байдалд халдах" (Kindeswohlgefährdung) гэсэн нэр томъёо, хууль зүйн тодорхойлолтын дагуу 1900 оноос эхлэн төр хүүхэд хамгааллын асуудалд оролцож эхэлсэн түүхтэй. Өнөөгийн байдлаар тус улсад Өсвөр насныхний гэмт хэргийн тухай хууль болон “хажуугийн” гэж нэрлэгддэг салбар хуулиуд, Хүүхэд хамгааллын тухай хуулиас дээрх тогтолцоо бүрдэж байна.

⁴⁰Self/peer exploitation – үе тэнгийнхэнтэйгээ онлайнгаар эсвэл цахим төхөөрөмжөөр дамжуулан бэлгийн харилцаанд орж буй зураг, видео бичлэг хийх, илгээх эсвэл хуваалцах

Зураг 11. Германы хүүхэд хамгааллын тогтолцоо



Герман улсад зарим зохион байгуулалтын бүтэц, журмыг шийдвэрлэсний үндсэн дээр улсын хэмжээнд хүүхэд, залуучуудын халамжийн үйлчилгээг орон нутгийн хүүхэд, залуучуудын халамжийн агентлагийн санал болгож буй бүтэц, дэмжлэгийг хүрээнд шийддэг. Герман улс нь цахим орчинд хүүхдийг хамгаалахтай холбоотойгоор Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын зөвлөлийн конвенц-д нэгдэн орсон бөгөөд уг конвенц-д нэгдэн орсон гишүүн улс орнууд нь “Хүүхдийн порнограф” буюу хүүхдийг садар самуун байдлаар үзүүлсэн материал түүнчлэн, техник, технологи ашиглан хүүхдийн дүр төрхтэй садар самуун дүрс, дүрс бичлэг бий болгох үйлдлийг хамруулж, хүүхдийн порнограф бүтээсэн, түгээсэн, дамжуулсан зэрэг үйлдлийг Эрүүгийн хуулийн дагуу шийтгэж байхаар зохицуулсан.⁴¹

Интернетэд хүүхдийн садар самууныг олж тогтоох, түүнтэй тэмцэх чиглэлээр ажилладаг Германы эрх баригчид удахгүй хүчирхэг шинэ хэрэгсэл болох хиймэл оюун ухаанаа ашиглана хэмээн зарласан. Германы хамгийн том муж болох Хойд Рейн-Вестфалийн Хууль зүйн сайд Питер Бисенбах “Microsoft” компанитай хамтран шинэ төсөл зарлаж, интернетэд хүүхдийн садар самууныг илрүүлэх ажлыг автоматжуулах төдийгүй шинэ AI технологи боловсруулаад зогсохгүй эдгээр асуудалтай тэмцдэг эрх баригчдын ажлын ачаалал, сэтгэлзүйн дарамтыг бууруулна хэмээн тооцоолж байна. “Хиймэл оюун ухаан богино хугацаанд их хэмжээний өгөгдлийг зохицуулж чаддаг бөгөөд энэхүү


⁴¹Council of Europe Convention on Cybercrime. United Nations Children’s Fund (UNICEF), The Innocenti Research Centre, Child Safety Online, Global Challenges and Strategies, 2012

хиймэл оюун ухааныг санаачлагчид хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд бүхэлд нь бэхжүүлэх зорилго тавьжээ. Эрх баригчид "Хиймэл оюун ухааны үндэсний анхны хэрэглээ"-г магтаж, "Хүүхдийн садар самуун нь хамгийн аюултай гэмт хэргийн нэг юм" хэмээн бүгд санал нэгтгэйгээр энэ ажиллагааг дэмжиж байна.

в) БНСУ: Тус улс нь хүүхдийг хамгаалах талаарх анхны хууль болох "Хүүхдийн сайн сайхан байдлын тухай хууль"-ийг 1961 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан ба Солонгосын дайны улмаас нийгмийн эмх замбараагүй байдал, эдийн засгийн хямралын үед тусламж шаардлагатай хүүхдэд энэ хуулиар туслалцаа дэмжлэг, үйлчилгээ үзүүлж байсан. Түүний дараа орчин үеийн хөгжлийн хандлагад нийцүүлэн "Хүүхдийн халамжийн тухай хууль"⁴² болгож /1999 оны 12 дугаар сарын 7-ны өдөр/ өөрчлөн найруулсан байдаг. Уг хуулийн зорилго нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тогтолцоог бий болгож, хүүхдийн аюулгүй байдлыг хангах бүрдэл, тогтолцоо, зарчим, боловсрол, хууль эрх зүйн стандартыг тогтоож өгчээ.

Ийнхүү 2000 оноос эхлэн хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгосноор Өмнөд Солонгос улсад хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах байдлаас хамгаалах талаар томоохон ахиц дэвшил гарчээ. Тус улсад 24 цагийн турш ажилладаг тусгай дугаарын утсаар /60 төв бүхий/ дамжуулан жилд дунджаар 29.000 мэдээллийг хүлээн авдаг ба дуудлага, мэдээллийг шалгаж, анхан шатны үнэлгээ хийж: "Хүүхдийн эрхийг зөрчсөн байх үндэслэлтэй" (72.3%), "Эрсдэл бүхий" (8.6%), "Үндэслэлгүй" (18.9%), "Хэрэг нээсэн" (0.2%) гэх зэргээр бүртгэгдсэн мэдээллийг ангилдаг.

⁴²<http://korea1391.go.kr/new/page/eng/cwa.php>



Structure of child protection in Korea (2009).

Тус улс нь “Хүүхдийн халамжийн тухай хууль”, “Хүүхэд хамгаалах болон өсвөр насны хүнийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах тухай” хуулиар хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг шалган шийдвэрлэдэг ба энэ чиг үүргийг БНСУ-ын Үндэсний хүүхэд хамгааллын газар хүлээдэг. Хэрэв гэмт хэргийн шинжтэй үйлдэл бүртгэгдсэн тохиолдолд цааш нь цагдаагийн байгууллагад шилжүүлж, хохирогчдод үзүүлэх яаралтай арга хэмжээ, хохирогчийг хамгаалах шийдвэр, хүчирхийлэл үйлдэгчид яаралтай эсхүл түр зуурын арга хэмжээ авах, хамгаалалтын хувилбарыг боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг. Мөн тус улс нь дээр дурдсан хуульд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тайлагнах үүргээ чангатгах ажлыг 2014 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.

Тус улсад “Хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн тухай онцгой хууль”⁴³ гэж байдаг бөгөөд энэ хууль нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргийн ял шийтгэл, түүний шат дамжлагын талаарх тусгай жишээ, хохирогч хүүхдийг хамгаалах арга хэмжээ, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчийг хамгаалах арга хэмжээг зааснаар хүүхэд аюулгүй нийгмийн бүрэлдэхүүн болж өсөх нөхцөлийг бий болгох зорилгыг тодорхойлсон. Уг хуульд хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол нэмж болон давхар яллах, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хязгаарлалтын бусад арга хэмжээг хэрэгжүүлж, хүчирхийлэгчийг хянах талаар тодорхой заасан.

БНСУ-ын өнөөгийн эрх зүйн зохицуулалтын дагуу интернет эрхийг (account) Солонгосын харилцаа холбооны стандартын хороо болон Үндэсний сонгуулийн хороо гэсэн төрийн хоёр байгууллага голчлон зохицуулдаг. Үндэсний сонгуулийн хороо нь сонгуультай холбоотой интернетэд байрласан

⁴³https://elaw.klri.re.kr/eng_service/lawAllSearch.do?pCode=01


бүх төрлийн мэдээ, мэдээллийг хянах бөгөөд сонгуультай холбоотой нийтлэл, сэтгэгдэл, блогийг устгах эрх хэмжээтэй байдаг. Харин Харилцаа холбооны стандартын хорооны хувьд өсвөр насныхан болон хүүхдэд хортой мэдээллийн агуулгыг тодорхойлж, хууль бус контент бүхий цахим хуудасны эсрэг арга хэмжээ авахаар зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд цахим гэмт хэрэгтэй холбоотой маргааныг зуучиллын журмаар зохицуулдаг байна. Энэ хүрээнд цахим хуудсыг хаах, хязгаарлах, зөрчилтэй мэдээллийг устгах даалгавар өгөх эрх хэмжээтэй байдаг.

Солонгос улсад өндөр хурдны интернет хурдтай хөгжихийн хэрээр техник, технологи, ухаалаг гар утасны хэрэглээний түвшин дэлхийн мэдээллийн технологийн цахилгаан станцыг бий болгож, үүний хэрээр цахим гэмт хэрэг газар авж эхэлжээ. Өсвөр насныхны дунд нийгмийн сүлжээ (SNS) гэх мэт харилцаа холбооны хэрэгслийг ашиглан садар самуун харилцаанд уруу татах гэмт хэрэгт хамгаалалтгүй өртсөөр нийгмийн ноцтой асуудал үүсч байгаа бөгөөд үүнд дэлхийн бусад улсуудын адил онцгой анхаарал, хандуулах шаардлагатай тулгарсан. Тус улс хүүхдүүдийг цахим бэлгийн халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор ноцтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боловсрол, цахим зохистой хэрэглээ, хувийн нэвтрүүлгийн журам, насанд хүрэгчдийн чат программыг баталгаажуулах журам, операторын залуучуудын хамгааллын үүргийг сайжруулан ажиллаж байна.

г) Олон улсын байгууллага: Internet Watch Foundation (IWF)

Зураг 13. IWF Цахим хуудас

Internet Watch Foundation (IWF) нь Их Британид бүртгэлтэй ашгийн бус байгууллага бөгөөд хүүхдийг бэлгийн бурангуй үйлдэл, бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглаж байгаа тохиолдлыг харуулсан зураг, видео бичлэг, агуулгын талаар мэдээллийг иргэдээс хүлээн авч, хууль бус агуулгыг интернет орчноос устгах ажлыг зохион байгуулдаг.



Иргэд тус байгууллагад мэдээлэл өгөхдөө өөрийн нэрийг нууцалж эсвэл ил тод мэдэгдэж болох бөгөөд иргэний мэдээллийг үнэн эсэхийг мэргэжлийн экспертүүд нягталж, хууль бус агуулгыг устгах, түүнийг түгээж буй хаягийг хаалгах арга хэмжээ авахуулдаг ажээ. Түүнчлэн, гэмт хэрэгтнийг олж илрүүлэх чиглэлд цагдаагийн байгууллагатай хамтарч ажилладаг байна. Манай улс 2020 оноос эхлэн www.ekids.mn цахим хуудсаар дамжуулан цахим орчин дахь Хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн материалыг мэдээлэх ажилд IWF-тэй хамтран ажиллаж байна.

Select Language Back to IWF website

IWF
Internet Watch Foundation

DO the right thing ✓

Make a Report

Hello & welcome to our reporting page

You can anonymously and confidentially report:

- Child sexual abuse images and videos
- Non-photographic child sexual abuse images

We know that seeing images and videos of child sexual abuse is upsetting. But if you stumble across it, reporting to us is the right thing to do.

Reporting is quick, easy and anonymous and it can lead to the rescue of a child victim from further abuse. But if you'd like to find out what happened to your report at a later date, we'll need your email address so we know how to contact you.

Warning! Reporting anything other than child sexual abuse imagery wastes valuable charity resources and prevents our analysts from finding and removing more child sexual abuse content online. If you'd like to report a child at risk or something other than an online image or video of child sexual abuse please click here.

Find out about our cookie policy

Click here if you have seen this before

What do you want to report?

Child sexual abuse picture or video What is this?

Non-photographic child sexual abuse image What is this?
(e.g. cartoons or computer-generated)

Want to remain anonymous?

Report anonymously
(Anonymous means you don't have to tell us who you are.)

I'm happy to give my details so I can request feedback
(If you'd like to know what happened with your report please use this option. We request that you only include your personal details in the designated fields on the following page, and not within the Description box.)

2018 онд тус байгууллага нь иргэдээс нийт 230 мянган мэдээлэл хүлээн авснаас 105 мянга нь гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдож, тухайн агуулга, зургийг устгасан байна. Тэдэнд ирсэн мэдээллээс харахад, гэмт хэргийн хохирогчдын 53% нь 10 болон түүнээс доош насны хүүхдүүд байгаа нь санаа зовоох асуудал болоод байгаа аж.

International Center for Missing and Exploited Children (ICMEC)



Сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах олон улсын байгууллага нь нэг ч хүүхдийг үлдээхгүйн төлөө хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар нөөцийг хувиарладаг, хүүхэд хамгааллын Олон улсын хамтарсан ажлын хэсэг, энэ чиглэлээр сургалт явуулдаг дэлхийн боловсролын төв юм. Тус байгууллага нь 1999 онд байгуулагдсан цагаасаа эхлэн хүүхэд хулгайлах, бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг зэрэг гэмт хэргээс хүүхдийг хамгаалах чиглэлээр дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж буй мэргэжилтнүүдийг сургах, нөөцөөр хангах, шаардлагатай техникийн туслалцааг үзүүлсээр иржээ. ICMEC нь технологийн тэргүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ, хүүхэд хамгааллын чиглэлээр газар дээр нь ажилладаг мэргэжилтнүүдийг сургах, энэ чиглэлээр ажилладаг гол оролцогч талуудтай хамтран ажиллах үйл ажиллагаа явуулдаг. Манай улсын хувьд, 2020 оноос эхлэн НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан цахим орчин дахь хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хууль сахиулах байгууллагын мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах асуудлаар тус байгууллагатай хамтран ажиллаж эхлээд байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд үндэслэн доорх дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Манай улсад хүүхэд хамгааллын эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдэж, хүүхэд хамгааллын талаарх төрийн бодлого тодорхойлогдон төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаа эрчимжиж байгаа хэдий ч цахим орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар нэгдсэн ойлголт байхгүйгээс Эрүүгийн хуульд нарийвчлан хуульчлаагүй тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн мэдээллийн урсгалд хяналт тавих эрх зүйн орчин, төрийн үйл ажиллагааны зохицуулалт сул байна.
2. Монгол Улс нь хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хэрэгждэг хэд хэдэн олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орж, соёрхон баталсан боловч цахим гэмт хэрэг, тэр дундаа цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бэлгийн мөлжлөг, бэлгийн зүй бус үйлдэлтэй тэмцэх, хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй олон улсын гэрээ, конвенц-д нэгдэн орох талаар санаачлага хангалтгүй байна.
3. Цахим гэмт хэрэг, ялангуяа цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувийн жин өсөх, гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох, цахим хэрэглээнд донтох эмгэг нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь дээрх чиглэлээр өмнө хийсэн хэд хэдэн судалгааны үр дүнтэй адилхан байна.
4. Судалгаанаас үзэхэд, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн гол шалтгаан, нөхцөл нь 1)ухаалаг гар утас, цахим төхөөрөмж, интернетийн хэрэглээ нэмэгдсэн, 2)цахим хэрэглээний соёл, мэдлэг дутмаг, 3) мэдээллийн урсгалд тавих хяналт хангалтгүй, 4) эцэг, эхийн хараа хяналт, хүүхдэдээ тавих анхаарал дутмаг, 5) эцэг, эхийн цахим хэрэглээний сөрөг нөлөөлөл, өөрсдөө цахим хэрэглээнд донтсон байдал, 6) хохирогчийн гэнэн итгэмтгий зан зэрэг байна.
5. Харин цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, дарамт, хүчирхийлэл үйлдэгчид нь ямар ч насны, ямар ч мэргэжлийн хүмүүс байх магадлалтайг судалгааны үр дүн харуулж байгаа бөгөөд тэдний дунд хүүхэдтэй хамгийн ойр ажилладаг багш мэргэжилтэй хүмүүс ч байгаа нь анхаарах асуудал юм.
6. Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдалтай тэмцэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, хуулиар хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлсэн хэдий ч оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ байхгүй, мэргэшсэн албан хаагчдын хүрэлцээ дутмаг байна. Мөн ийм төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэхдээ хохирогч болон гэмт хэрэг үйлдэгчдийн талаар нарийвчилсан бүртгэл, судалгаа байдаггүй тул энэ төрлийн гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх оновчтой стратеги боловсруулж чадахгүйд хүргэж байна.

7. Герман, Солонгос, Канад, Их Британи зэрэг гадаад орны туршлагаас харахад, хүүхдийг сөрөг агуулгатай контентээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг мэдээлэл харилцаа холбооны асуудлыг хариуцсан төрийн болон хувийн хэвшлийнхний хамт хэрэгжүүлж байна. Түүнчлэн, хүүхдийн цахим орчинд хамгаалах асуудалд эцэг, эх, олон нийтийг сургаж бэлтгэх, нягт хамтран ажиллах үйл ажиллагаанууд амжилттай үр дүнг авчирч байгаа сайн туршлага байгааг манай улсад нэвтрүүлэх боломжтой.

Судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээг судалж, бүс нутгийн хэмжээнд цахим гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ, мэдээллийн системд элсэж, сайн туршлагыг нэвтрүүлэх, үр дүнг тогтмол үнэлэх механизмтай болж улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх стратеги бодлогодоо тусгах;
2. Цахим орчин дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг болон бэлгийн бурангуй үйлдлээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх салбар дундын зохицуулалтыг хангасан тусгайлсан хуультай болох;
3. Хүүхэд цахим орчинд гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэхийн тулд цахим орчин дахь хохирогч болох эрсдэлтэй хүүхдүүдийн зан үйл, эрсдэлт нөхцөл байдал болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж буй гэмт этгээдүүдийг гэмт хэргийн сэдэл шалтгаан, урьтач нөхцөл болон тэдний сонирхол зан үйлийг ойлгох нарийвчилсан суурь судалгааг тусгайлан хийх, ингэснээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх боловсролын болоод технологийн шийдэл, стратегийг зөв тодорхойлох;
4. Цахим орчинд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах тусдаа тасаг байгуулах асуудлыг судлах, шаардлагатай технологийн болон хүний нөөцөөр хангах, энэ чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх, сургалт болон технологийн шинэчлэлийг мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан байнга шинэчилж байх;
5. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэлд өртөж хохирсон, холбогдсон талаарх тоон мэдээлэл, судалгааг олон төрөл үзүүлэлтээр гаргаж, бодлого, үйл ажиллагаандаа ашигладаг байх, олон нийтэд нээлттэй байдлаар мэдээлэхэд хуулийн болон хүүхдийн эрхийн байгууллагууд анхаарч ажиллах;
6. Мөрдөгч нарыг бэлтгэн гаргадаг Дотоод хэргийн их сургуулийн төдийгүй хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт цахим орчин дахь гэмт хэргийг мөрдөн шалгах, хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгтэй холбоотой агуулга оруулах, мөн хууль сахиулах байгууллагын алба хаагчид, хуульчдад зориулсан хуульчийн үргэлжилсэн сургалтад уг сэдвийг тусгайлан оруулах замаар албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх;
7. Цахим орчинд, ялангуяа нийгмийн сүлжээнд хүүхдийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх, энэ зорилгоор ХХЗХ, МХХЗГ зэрэг төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийнхэн хоорондоо идэвхтэй хамтран ажиллах, e-mongolia цахим монгол хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулах;
8. Гэр бүлийн орчинд цахим хэрэглээнд эцэг эхийн хяналт буюу parental control-ийг нэвтрүүлж, IPTV болон өргөн хэрэглээний сувгийн эрх

эзэмшигчдээс тодорхой зөвлөмж, аргачлалыг нэгдсэн байдлаар хүргэх. Мөн сургуулийн орчинд цахим хэрэглээг хязгаарлахдаа зөвхөн суралцахад тохиромжтой дата сан, хэрэглэгчийн эрх үүсгэж харилцах, тодорхой мэдээлэл, мэдлэгийг нийтийн сүлжээ ашиглан хүргэхгүй байх талаар хуулийн этгээд, сургалтын байгууллагыг хуулиар үүрэгжүүлэх, шаардлагатай гэж үзвэл зарим үйлдлийг зөрчилд тооцож, шийтгэл оногдуулах замаар эрсдэл хүчин зүйлийг бууруулах;

9. Үндэсний хэмжээнд зөвхөн насанд хүрэгчдэд IP хаяг буюу интернет хаяг үүсгэж нийтийн сүлжээ болон насны хязгаарлалтай сайтад хандах эрхтэй болгох;
10. Төрийн бус байгууллага зарим хуулийн этгээдийг цахим орчинд хүүхдийг эмчлэх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг дэмжин туслах, санхүүжүүлэх, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авах;
11. Цахим хэрэглээг зүй зохистой болгох мэдлэг олгох зорилгоор албан болон албан бус боловсролын хичээлийн хөтөлбөрт энэ талаар тусгайлсан сэдэв тусган оруулах, мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан байнга шинэчилж байх, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас үндэсний хэмжээнд бүхий л сургуулийг тусгайлсан цахим сургалтын орчинг үүсгэж, эцэг эхтэй харилцах цонхыг хөгжүүлэх зэрэг болно.

Судалгааны үр дүнд үндэслэн дор дурдсан зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газарт

- Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хамтран ажиллах талаарх олон улсын гэрээ, конвенцыг судалж, нэгдэн орох ажлыг зохион байгуулах;
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах;
- Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг цахим халдлагаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;
- Цахим гэмт хэрэг, халдлагад өртсөн хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамгаалах үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий холбон зуучлах тогтолцоог бүрдүүлэх.

2. Улсын ерөнхий прокурорын газарт

- Цахим орчинд хүүхэд хохирсон талаарх бүртгэл, судалгаа, мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж, холбогдох байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах;
- Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэгт хяналт тавих чиглэлээр зарим прокуроруудыг мэргэшүүлэн сургаж, ажиллуулах.

3. Шүүхийн ерөнхий зөвлөлд

- Шүүхийн судалгаа, мэдээллийг олон нийтэд нээлттэй, шийдвэр гаргахад ашиглагдахуйц байдлаар мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглалтыг хангаж ажиллах.

4. Хууль зүй, дотоод хэргийн яаманд

- Цахим гэмт хэрэг, цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт үйлдэл, эс үйлдэхүйг эрүүгийн хууль тогтоомжид хуульчлах, хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах.

5. Эрүүл мэндийн яаманд

- Цахим хэрэглээнээс үүдэлтэй өвчин эмгэг судлалыг хөгжүүлж, түүний үр дүн, урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг нийтэд түгээх.

6. Боловсрол, шинжлэх ухааны яаманд

- Хүүхдийн насны онцлогт тохирсон цахим хэрэглээг хяналттай, хязгаартай байдлаар нэвтрүүлэх бодлогыг боловсролын бүх шатанд хэрэгжүүлэх;
- Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүнийг сургууль, боловсролын байгууллагад ажилд авахгүй байх асуудалд анхаарах, холбогдох лавлагаа, мэдээллийг цагдаа, шүүхийн байгууллагаас авч тодруулдаг байх;

- Цахим хэрэглээний донтолт, түүний хор уршиг, цахим халдлагаас хамгаалах талаар бүх нийтийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

7.Цагдаагийн ерөнхий газарт

- Цахим гэмт хэрэг, халдлагыг бүртгэх, шалгах, хянах чиг үүрэг бүхий нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах, орчин үеийн дэвшилтэт техник технологиор хангах;
- Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйл, чиг хандлагыг жил бүр тодорхойлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

8.Харилцаа, холбооны зохицуулах хороонд

- Хүүхдийн цахим хэрэглээнд хяналт, хязгаар тавьж, зохистой хэрэглээг бий болгох техникийн шийдлийг нэвтрүүлэх.

9.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

- Хүүхэд, залууст цахим хэрэглээний зохистой байдлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлуудыг явуулах;
- Эцэг, эхчүүд хүүхэдтэйгээ амьд харилцаа үүсгэх ач холбогдлын талаар зөвлөмж боловсруулж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах.

10.Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд

- Цахим хэрэглээнд донтох эмгэгийн эмчилгээний чанарыг сайжруулж, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах.

11.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад

- Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, гэмт хэрэг гарахгүй байх асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд холбогдох байгууллагаар дамжуулан авч хэрэгжүүлэх;
- Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд цахим хэрэглээг зөв, зохистой хэрэглэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг тогтмол өгдөг байх.

12.Хувийн хэвшлийн байгууллагад

- Хүүхэд цахим орчинд эрсдэлд, гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөхгүй байхад бизнесийн үйл ажиллагаагаа чиглүүлэх;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд цахим хэрэглээг зөв, соёлтой, зохистой хэрэглэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг тогтмол өгдөг байх.

13.Эцэг, эхэд хандаж

- Цахим хэрэглээг зохистой түвшинд байлгах, аюулгүй, эрсдэлгүй байхад онцгойлон анхаарах;
- Хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшил, хөгжилд зөв, оновчтой ашиглах талаар анхаарал, хяналт, дэмжлэгийг сайжруулах.

---oo0oo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Монгол Улсын хууль

- Эрүүгийн хууль. 2002
- Зөрчлийн тухай хууль. 2017
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017
- Харилцаа холбооны тухай хууль. 2001
- Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016
- Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. 1998
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 2011

Хоёр. Судалгааны тайлан, ном бүтээл

- Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан. ГБХЗХГ. 2018 он
- Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал: SWOT шинжилгээ судалгааны тайлан. 2017
- Гэмт хэрэг статистик зүйн гарын авлага. Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. 2020
- Нээлттэй нийгэм форум, Дотоод хэргийн их сургууль. “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны тайлан. 2020
- Монголын эмэгтэйчүүдийн сан, Дотоод хэргийн их сургууль, Хүйсийн тэгш эрхийн төв төрийн бус байгууллага. “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны тайлан. 2019
- Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар “Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, мэдээлэл технологийн зохистой хэрэглээг дэмжих ажлын тайлан”. УБ, 2018,
- Хүүхдийн хүмүүжил ба ген Такахаши Такао, 2020,
- Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал, Д.Санжжав, 2012,
- Хүмүүжлийн тухай яриа.. Б.Бор. УБ., УХХЭХ. 1970.
- Хүүхдийн мэдрэл төрх байдал. Б.Бор. УБ., 1970.
- Хүүхдийг хүмүүжүүлэхээ боль-өсөн торниход тусал гарын авлага Заряна Незрасова, УБ., 2010.
- Хүүхэдтэй хэрхэн яаж зөв харьцах вэ?, Юлия Борисовна Гиппенрейтер, 2020,
- Багачуудын тухай насанд хүрэгсдэд өгүүлэх нь. Ш.Содномпилын орчуулга. УБ., 1973.
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжилт. Д.Санжжав. УБ., 1974.
- Сэтгэл судлал, хүүхэд бүрийн хөгжил, О.Мягмар, 2016.

Гурав. Байгууллагын мэдээлэл, судалгаа

- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тайлан
- Улсын Ерөнхий Прокурорын газрын тайлан
- Цагдаагийн ерөнхий газрын тайлан

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тайлан
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлан

Дөрөв. Цахим эх сурвалж:

1. Арван хүүхэд тутмын найм нь цахим сүрдүүлэгт өртөж байна. <https://news.zindaa.mn/>
2. Бид цахим ертөнцөд биш бодит ертөнцөд амьдардаг юм шүү оллоо.mn
3. Дэлгэцэнд донтох хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгджээ <https://mass.mn/n/54160>
4. Дэлгэцийн донтолт 10-21 насныхан дунд өндөр байна. <https://news.mn/r/749028/>
5. Монгол хүүхдийн 92 хувь нь интернет хэрэглэж байна <https://montsame.mn/>
6. Монгол уламжлал дахь хүүхдийн хүмүүжил
7. Нэг удаа ч гэсэн хүүхдийнхээ гар утсыг шалгаж анхаараач ээ гэж зөвлөмөөр байна. <https://dnn.mn/>
8. Өсвөр насны хүүхдүүдийг хаалттай группт элсүүлэн нүцгэн зураг, хувийн мэдээллийг нь авч сүрдүүлсэн, дарамталсан хэргүүд шалгагдаж байна. <https://dnn.mn/>
9. Өсвөр үеийнхнээ дэлгэцийн донтолт, кибер аюулаас хамгаалъя. <http://www.ontslokh.mn/134554.html>
10. Сурагчид тэнэгүүдийг дэлхийгээс зайлуулах хөдөлгөөн”, “халтаруудаас салъя” гэх мэт цахим гадуурхах хөдөлгөөнийг өрнүүлдэг болжээ. <https://dnn.mn/>
11. Хүүхдэдээ цахим орчинд чөлөөтэй аялах зав бүү гарга <https://www.maamuu.mn/>
12. Хүүхдээ цахим орчны хяналтгүй хэрэглээ-нээс хамгаалаарай! <https://eyreg.mn/2019/06/12/>
13. Хийсвэр соёл “Гаж хүн”-ийг төрүүлж байна. Д.Сандагсүрэн “Монголын мэдээ сонин”
14. Хүүхэд цахим орчинд байнга байвал зан байдалд нь том өөрчлөлт орно. <http://itoim.mn/>
15. Хүүхдийг цахим донтолтоос гаргах нь дан ганц эмчийн үүрэг биш <http://www.arслан.mn/social/health/>
16. Хүүхдээ дэлгэцийн донтолтоос хамгаалахын тулд та өөрөө дэлгэцээс холдох хэрэгтэй. <http://www.tusgal.mn/>
17. Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал <https://gia.gov.mn/12/item/709/>
18. Цахим орчны зохицуулалт, цахим тоглоомын насны ангилал <http://crc.gov.mn/contents/raw/12/3/277/2015.12.01-crc.pdf>
19. Интернетийн хэт хэрэглээ Монголын төдийгүй дэлхийн тулгамдсан асуудал болсон <https://www.24tsag.mn/a/>
20. Цахим орчин дахь амьдрал бодит ертөнцөөс ч аюултай байж мэднэ <https://dnn.mn/>
21. “Цахим орчинг зөв болгоё” аян эхэллээ <https://dnn.mn/>
22. “Цэнхэр халим” хэмээх хий үзэгдэл монгол хүүхдүүдийг ангуучилсаар байх уу. <https://dnn.mn/>
23. Цахим орчинд таны хүүхдийг танихгүй хүмүүс хүмүүжүүлж байна. <https://dnn.mn/>

24. Цахим сүлжээтэй холбогдуулж хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай. <https://dnn.mn/>
25. Цахим орчны зохистой хэрэглээ <http://crc.gov.mn/contents/raw/>
26. Цахим орчин дахь хүүхэд хамгаалал <https://dnn.mn/>
27. Цахим бороохой. <https://dnn.mn/>
28. Цахим орчноос хүүхэд ямар мэдээлэл авч байгааг эцэг эхчүүд хянадаг болно. <https://dnn.mn/>
29. Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” <https://montsame.mn/>
30. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих ажлын тайлан <http://child.gov.mn/>
31. Эцэг, эхчүүд хүүхдэдээ хэр цаг гаргаж, халамжилна тэр хэрээр цахим донтолтоос хамгаална. <https://ncmh.gov.mn/>
32. Утсандаа донтсон хүүхэд архи, хар тамхинд ч донтох өндөр эрсдэлтэй. <http://itoim.mn/>

---oo0oo---

СУДАЛГААНЫ БАГ:

Багийн ахлагч:

О.Зоригт ДХИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Нарийн бичгийн дарга:

С.Энхбаатар ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн ахмад

Гишүүд:

П.Батбаатар ЦЕГ-ын Санхүү аж, ахуйн албаны дарга, цагдаагийн хурандаа

Э.Халиунбаяр ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа

Г.Уянга мөн албаны Статистик, мэдээллийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

Д.Будзаан ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга, цагдаагийн хошууч

Б.Алтансүх ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч

О.Уулзахжаргал мөн газрын мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч

Б.Мөнхдорж ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

Н.Сайнбаяр мөн нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн докторант, цагдаагийн ахмад

Б.Билгүүн мөн нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, цагдаагийн дэслэгч

Д.Цэрэнлхам ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч

Ц.Баясгалан ДХИС-ийн Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын Чанарын баталгаажуулалтын төвийн ахлах мэргэжилтэн, эдийн засгийн ухааны доктор, дэслэгч

Г.Оюунболд Улсын Ерөнхий Прокурорын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ, сургалтын хэлтсийн хяналтын прокурор

Э.Ганцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ахлах референт

Л.Цэрэндолгор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхэд өсвөр үеийн клиникийн эрхлэгч

Зөвлөх:

Б.Энхболд Хууль зүйн доктор, дэд профессор

С.Гантулга Хууль зүйн доктор, дэд профессор